

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2019 ОНЫ 5 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2019.06.04

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид энэ сард 2 удаа хуралдаж 31 асуудал хэлэлцэж 29 тогтоолыг баталлаа. Үүнд:

-Аймгийн төр төсвийн байгууллагад зайлшгүй хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг 2019 онд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан баталлаа.

-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах аймгийн орон тооны байнгын ажлын хэсгийг 17 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, 2019 оны цэргийн албыг биеэр дүйцүүлэн сумдад хаах иргэдийн тооны дээд хязгаарыг Баруунбүрэн суманд 15, Сайхан суманд 10, Хушаат суманд 5 нийт 30 иргэн байхаар тогтоов.

-”Сэлэнгэ байгалийн нөөц” ХХК-ийн 34 хувийн хувьцаа эзэмшигч “Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ-ын эзэмших 34 хувийн хувьцаанаас 8 хувийг Баянгол суманд шилжүүлэхийг зөвшөөрөв. Мөн “Сэлэнгэ байгалийн нөөц” ХХК-ий 66 хувийн хувьцаа эзэмшигч “Сэргээгдэх байгалийн нөөц” ХХК нь өөрийн эзэмшлийн 50 хувь буюу компанийн нийт хувьцааны 33 хувийг бусдад шилжүүлэхийг зөвшөөрлөө.

Аймгийн ИТХ-аас батлан гаргасан тогтоол, шийдвэр, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тухай тогтоолыг баталж, Орхонтуул суманд үйл ажиллагаа явуулж байгаа христийн шашны “Орхонтуул эзний хайр” чуулган, Ерөө суманд үйл ажиллагаа явуулж байгаа христийн шашны Ерөө баптист, Бугант баптист сүм, Баянгол суманд үйл ажиллагаа явуулж байгаа христийн шашны “Эзний давалгаа баптист” сүм, Ерөө суманд “Ерөө Нэгдсэн Методист” христийн шашны сүм байгуулж дүрмийн дагуу шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар тус тус олгов.

-Атар газар эзэмшсэний 60 жилийн ойг тохиолдуулан мал аж ахуй, газар тариаланг хослуулан хөгжүүлж Атрын аянуудад манлайлан оролцож, улсынхаа хөгжил цэцэглэлт, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Түшиг сумыг Алтан гадас одонгоор шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа. Мөн ойг тохиолдуулан төрийн захиргааны болон хүнс, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан Ичинхорлоогийн Цэрэнчимэд, Нацагийн Дэлгэрмөрөн, Доржпаламын Арвин, Дашдэлэгийн Болд, Шаравын Гунгаадорж, Чойжсүрэнгийн Мөнхцэцэг, Нянгарын Цээрэн, Чүлтэмийн Чунд нарыг МУ-ын “Хөдөлмөрийн баатар” цолоор, Жалсрайн Баярмагнай, Ямаранзын Идэрнамнан, Махбалын Тэрбиш, Гаадайн Уртнасан, Аймгийн Үржлийн цөм сүргийн аж ахуйн захирал Дагвын Бадарч, Орхонтуул сумын ахмад тариаланч Батаагийн Эрдэнэтогтох нарыг МУ-ын “Гавьяат агрономич” цолоор, Луусангийн Баатар, Лхүмбийн Сандаг, Цоодолын Тогоодой, Лхамсүрэнгийн Цэрэнчимэд, Мягмарын Шинэчулуун, Сэдбайдарын Баатар, Банзрагчийн Баатар, Балжирын Баянбилэг, Юмжилын Жигмэддорж, Очиржанцангийн Оюунцэцэг, Дандарын Пүрэвсүрэн, Зонровын Хонгор, Лхагваагийн Цандэлэг, Нанзадын Чимэд, Доожийн Чулуунбаатар нарыг “Хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч” цолоор, Цэрэндоржийн Ганбаатарыг “Гавьяат мал зүйч” цолоор, Хүнс хөдөө аж ахуйн сайдын ажлын албаны ахлах зөвлөх Рэгжийбуугийн Нямсүрэн, Сүхбаатар сумын 2 дугаар сургуулийн захирал Содномпилийн Энхтайван нарыг “Гавьяат багш” цолоор, Аймгийн Зохиолчдын салбарын чөлөөт уран бүтээлч Нямжавын Сүхдоржийг “Соёлын гавьяат зүтгэлтэн” цолоор, Цагааннуур сумын харьяат, Сумо бөхийн Үндэсний шигшээ эмэгтэй багийн ахлагч Хишигдоржийн

Сүнжидмаа, Шаамар сумын харьяат, Үндэсний шагайн харвааны холбооны дэд ерөнхийлөгч Сандуйжавын Энхтөр нарыг “Гавъяат тамирчин” цолоор, Түшиг сумын ахмад настан Шаравын Баясгалан, Түшиг сумын тариаланч Шагдарын Бямбаа, Сүхбаатар сумын ахмад настан Чимэдийн Даваадорж нарыг “Сүхбаатарын одон”-оор, мөн эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим иргэдийн төрийн одон, медалиар шагнуулахаар шийдвэрлэж, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 46, Алтан гадас одонгоор 194, Хөдөлмөрийн хүндэт медалиар 336, “Атарчдын алдар” медалиар 31 иргэнийг шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид тус тус уламжлахаар шийдвэрлэж, спортын салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан Зүүнбүрэн сумын иргэн Монгол улсын начин Чүлтэмийн Мөнхтогтохыг аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагналаа.

-Аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга Э.Оюунболдыг нутгийн өөрөө удирдах байгууллагын туршлага судлах ажлаар Бүгд Найрамдах Словак улсад ажиллуулахаар томилов.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан 5р сарын 24-ний өдөр тус аймагт ажиллаж хаврын тариалалтын явц, бодит байдалтай газар дээр нь танилцлаа. Цагааннуур сумын “Сэлэнгэ тариа” ХХК, Хушаат сумын “Мо Мо Агро” ХХК, “Цэгээн Хуст” ХХК-уудын тариан талбайгаар орж тариалалтын явцтай, Зүүнбүрэн сумын “Газар Агро” ХХК-ий эрчимжсэн үхрийн аж ахуйтай тус тус танилцсан.

Аймгийн хэмжээнд энэ онд нийт 180507 га талбайд тариалалт хийхээс 6-р сарын 4-ний байдлаар 152742 га-д тариалалт хийж, тариалалтын явц 84,6 хувьтай байна. Үүнээс 124112 га-д улаанбуудай, 808 га-д арвай, 2532 га-д овьёос, 1464 га-д гурвалжин будаа, 8068 га-д тэжээлийн ургамал, 15758 га-д тосны ургамал буюу рапс, 2064 га-д төмс, 1561 га-д хүнсний ногоо тариалсан мэдээтэй байна. Хаврын тариалалтын мэдээг долоо хоног бүрийн 2, 5 дахь өдрүүдэд Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэн ажиллаж байна.

Газар тариалангийн өлгий Сэлэнгэ нутаг атар газар эзэмшсэний түүхт 60 жилийн ойг угтан "Атрын нутгийн хурд-2019" хурдан морины хаврын бүсийн уралдааныг 5-р сарын 13-нд зохион байгууллаа. Уралдааны хурдан Их насны морьдын түрүү магнайд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Ганболдын сартай зээрд хурдалж, Булган аймгийн Булган сумын Цэнгэлийн хүрэн аман хүзүүдэж, Дундговь аймгийн Ганцогтын ногоон цоохор гурвалсан бол Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын П.Мөнхтөрийн хул болон хээр, Соёолон насны морьдын уралдааны түрүү магнайд Орхон аймгийн Баян-Өндөр сумын Ж.Оргилын хээр хурдалж, Төв аймгийн Аргалант сумын Г.Батчулууны зээрд аман хүзүүдэн, Сэлэнгэ аймгийн Хушаат сумын Д.Алтансүхийн хээр алаг, Төв аймгийн Заамар сумын Мөнхбаярын бор, Сэлэнгэ аймгийн Сант сумын Золбаярын саарал, Хязаалан насны морьдын уралдаанд Увс аймгийн Тэс сумын Ж.Төмөрбаатарын хамар цагаан түрүүлж, Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Д.Бямбасүрэнгийн хул, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Ц.Баярбатын хээр, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Т.Цогдоржийн хул, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Л.Эрдэнэбатын халтар, Шүдлэн насны морьдын түрүү магнайд Говь-Алтай аймгийн Баян-уул сумын Б.Амарсайханы хүрэн хурдалж, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Г.Хадбаатарын бор, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны С.Цэрэннадмидын бор, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Б.Хонгорын хонгор, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Б.Гүенбаатарын хүрэн халзан, хурдан дааганы уралдаанд Төв аймгийн Угтаал сумын Баттулгын зээрд хонгор түрүү магнайд хурдалж, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Д.Мөнхтулгын хээр, Дархан-уул аймгийн Орхон сумын Б.Ариунболдын хүрэн, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын А.Алтанбаганын саарал, Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Г.Энхбаясгалангийн хул айрагдлаа.

Эрлийз дээд насны түрүү магнайд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Г.Энхтайваны бор түрүүлж, Төв аймгийн Угтаал сумын Ж.Баттулгын зээрд, Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын А.Баттөмөрийн хээр, Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын Р.Бямбаагийн хүрэн халзан, Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Ш.Оргилын халтар

хурдаллаа. Эрлийз дунд насны түрүү магнайд Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын А.Мөнхбаярын хар, аман хүзүүнд Төв аймгийн Заамар сумын Ж.Түмэн-Өлзийн хээр хурдалж, Сэлэнгэ аймгийн Сант сумын Ч.Балжиннямын хээр, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын С.Гантөмөрийн тод хүрэн, Төв аймгийн Борнуур сумын Х.Баасанбатын халтар айрагдсан. Эрлийз дааганы түрүү магнайд Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын А.Амарсайханы сартай хээр хурдалж, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Ж.Оргилын хүрэн халзан аман хүзүүдэж, Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын Энхбатын хээр халзан, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар С.Гантөмөрийн тод хүрэн, Төв аймгийн Борнуур сумын Х.Баасанбатын халтар айрагдлаа. Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Б.Баянбилэгийн хонгор, Сэлэнгэ аймгийн Түшиг сумын М.Баярмандахын сартай хээр даага монгол болон эрлийз төрөлд энэ наадмын баян ходоод, ирэх жилийн түрүү магнай болохоор цолоо дуудууллаа.

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, хууль зүйн ухааны доктор П.Оюунчимэг тэргүүтэй ХЭҮК-ын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга Т.Тамир, ХЭҮК-ын референт Х.Цэцэгээ, Г.Золзаяа нарын бүрэлдэхүүнтэй ажлын баг энэ сарын 23-24-ний өдрүүдэд тус аймагт ажиллаж, комиссын бүсчилсэн сургалтын төлөвлөгөөний дагуу төвийн бүсийн сургалтыг зохион байгууллаа. Жендер ба хүний эрх” сэдэвт сургалтад нийт 87 төрийн албан хаагчид хамрагдсан. Энэ үеэр аймаг, сумын ИТХ, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагуудад ажиллаж, ажил байдалтай нь танилцлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 150 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/46 дугаар захирамжийн дагуу 2019 онд зохион байгуулагдах "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг"-т бэлтгэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газраас Архивын ерөнхий газар, Төрийн албаны зөвлөлтэй хамтран сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, төр, төсвийн байгууллагын удирдлагууд, архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудад зориулсан "Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг"-ийн бэлтгэл хангахад анхаарах асуудлууд, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд батлагдан гарсан хууль тогтоомжийн талаарх сургалтыг 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулж, 400 гаруй төрийн албан хаагчдыг хамрууллаа.

Мөн улсын үзлэгтэй холбогдуулан 5 дугаар сарын 15-ны өдөр Төрийн албаны зөвлөл, Архивын ерөнхий газрын хамтран зохион байгуулсан "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг"-ийн дүгнэх үзүүлэлт, анхаарах асуудлын талаарх цахим сургалтад аймаг, сумдын ИТХ, аймгийн ЗДТГазар, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, төр, төсвийн байгууллагын удирдлагууд, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан нийт 150 гаруй ажилтнуудыг хамрууллаа.

Аугаа их эх орны дайны Ялалтын 74 жилийн түүхэн ойг тохиолдуулан Алтанбулаг суманд байрлах Зөвлөлтийн дайчдын хөшөөнд цэцэг өргөж хүндэтгэл үзүүлэх уламжлалт үйл ажиллагаа 5-р сарын 6-ны өдөр боллоо. Хүндэтгэлийн арга хэмжээнд Сэлэнгэ аймгийн ИТХ-ын дарга, Засаг даргын орлогч, ОХУ-аас Дархан-Уул аймагт суугаа Ерөнхий консул болон Алтанбулаг сум, Хиагтын районы удирдлагууд, Орос, Монголын чөлөөлөх дайны ахмад дайчид, төр захиргааны ахмад ажилтнууд, нутгийн ард иргэд оролцлоо. аймгийн Нэгдсэн музейн хашаанд барьж шинэ хөшөөний нээлтийг давхар хийсэнд оршиж байв. Зочид, төлөөлөгчдөд зориулан Алтанбулаг сумын сургуулийн сурагчид, "Сэлэнгийн долгио" чуулгын уран бүтээлчид, Таван хан морин хуурын чуулгын сурагчид ая дууны мэндчилгээ дэвшүүллээ.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 05 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах, төр, төсвийн байгууллагын ажилтан албан хаагчид, иргэдийн дунд нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, бие бялдарыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, байгууллага хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд энэхүү тэмцээний зорилгоор жил бүр уламжлал болгон

зохион байгуулдаг аймгийн Засаг даргын нэрэмжит спортын нөхөрсөг тэмцээн 5-р сарын 2-5-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тэмцээнийг ажлын байрны дасгал, усанд сэлэлт, дартс гэсэн төрлүүдээр нэмэгдүүлж, сагсан бөмбөг, волейбол, орс таталт, ширээний теннис, шатар гэсэн 8 төрлөөр явуулж, нийт 20 багийн тамирчид өрсөлдөж, багийн нийлбэр дүнгээр тэргүүн байранд Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Зооноз-төвийн хамтарсан баг, 2-р байранд Гаалийн газар, 3-р байранд Шүүх, Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Шүүхийн шинжилгээний албаны хамтарсан багууд шалгарлаа. Энэ арга хэмжээний үеэр аймгийн Засаг дарга эх орон, төрөлх нутгийнхаа нэрийг дэлхийн тавцнаа цуурайтуулан мандуулсан авъяаслаг хүүхэд багачууддаа хүндэтгэл үзүүлж мөнгөн урамшуулал олгон алдаршууллаа. Жижиуцү бөхийн Дэлхийн аваргын алтан медальт Сүхбаатар сумын 2-р сургуулийн сурагч Б.Шинэтулга, Жижиуцү бөхийн Дэлхийн аваргын алтан медальт “Шинэ Бадрах” дэвжээ Спорт сургуулийн сурагч Г.Батцэцэг нар 3 сая, Жижиуцү бөхийн Дэлхийн аваргын мөнгөн медальт Спорт сургуулийн сурагч С.Шинэхүү 2 сая, Жижиуцү бөхийн Дэлхийн аваргын хүрэл медальт “Шинэ Бадрах” дэвжээ Спорт сургуулийн сурагч Г.Мөнхтуяа 1 сая төгрөгийн эзэд боллоо. Мөн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль хүртсэн баг тамирчдыг мөнгөн шагналаар урамшууллаа.

Онцгой байдлын газрын ажил үйлчилгээний талаар

МУ-ын Шадар сайдын баталсан “Үйлдвэрийн барилга байгууламж”-д хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийн дагуу “Хөтөл-Цемент шохой ХК”-д гүйцэтгэлийн шалгалтыг хийж, үйлдвэрийн шохойн үйлдвэр, чулуунцарын үйлдвэр, цемент үйлдвэрлэх цех, дулааны станц, уул авто тээврийн цех, чулуунцарын нүүрсний хэсэг, нүүрс түүхий эд бэлтгэх талбай, тэсрэх материалын агуулах, засварын нэгдсэн цех, сорил шинжилгээний лаборатори цех, хангамжын материал хадгалах агуулах, төмөр замын хэсэг, зочид буудал, захиргааны барилга зэрэг 14 цехийн барилга байгууламж хамрагдаж, шалгалтын явцад илэрсэн 72 зөрчлөөс гүйцэтгэлийн шалгалтаар 53 зөрчил дутагдлыг засуулах арга хэмжээ авлаа. Мөн төлөвлөгөөт шалгалтыг төмөр бетон дэрний үйлдвэрт хийж, нийт 8 зөрчлийг илрүүлж, үзлэг шалгалтын явцад 2 зөрчлийг арилгуулж, бусад зөрчлийг арилгуулахаар гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 1, танилцуулга 1 өгсөн. Мөн газрын даргын баталсан “Эрүүл мэндийн байгууллагууд”-д гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт шалгалтын удирдамжийн дагуу галын аюулгүй байдалд нь үнэлгээ, дүгнэлт өгч, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хангуулж ажиллаа. Шалгалтанд Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулдаг Эрүүл мэндийн байгууллагууд, эмийн сан зэрэг нийт 28 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт, шалгалт хийж нийт 143 зөрчлийг илрүүлж, үзлэг шалгалтын явцад 6 зөрчлийг арилгуулан, бусад зөрчлийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 5 үйлдэж байгууллагын дарга, эрхлэгч нарт өгсөн.

Сэлэнгэ аймгийн Сум дундын Прокурорын газар, Сумын Засаг даргын тамгын газар, Онцгой байдлын газрын “Шатахааун түгээх станц, шингэрүүлсэн хийн түлшний станц”-уудад хяналт шалгалт хийх хамтарсан удирдамжийн дагуу Галын аюулгүй байдлын тухай хууль, барилга байгууламжийн аюулгүй байдлын норм дүрэм, стандартын хэрэгжилтэт хяналт шалгалтыг явуулж, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдалд нь үнэлгээ, дүгнэлт өгч, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хангуулж ажиллаа. Хяналт шалгалтанд: “Шунхлай” ХХК-ны Хөтөл-ШТС, “Тэс петролиум” ХХК-ны Номгон-ШТС-47, Хөтөл-ШТС-26, “Ник” ХХК-ны Хөтөл-ШТС, “Магнай трейд” ХХК-ны Хөтөл-ШТС-51, “Дашваанжил” ХХК-ны АХЦС зэрэг аж ахуйн нэгж байгууллагын нийт 6 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт, шалгалтыг хийж нийт 41 зөрчлийг илрүүлж, үзлэг шалгалтын явцад 8 зөрчлийг арилгуулан, бусад зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 5, мэдэгдэл 1, Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт-2, зөвшөөрөл-1 байгууллагын дарга, эрхлэгч нарт өгч ажиллалаа.

Аймгийн Онцгой байдлын газар 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд объектын гал түймрийн-11, эрэн хайх аврах ажиллагааны дуудлага-4, ой, хээрийн түймрийн дуудлага 6 нийт 21 удаагийн дуудлагаар ажиллаж шуурхай хариу арга хэмжээ авч ажиллаж байна.

Үүнээс гадна объектын гал түймрийн дуудлагаар Сүхбаатар сум 3 удаа, Баянгол сум 3 удаа, Мандал сум 3 удаа, Төв аймгийн дуудлагаар 1 удаа Баянгол сумын ГТУА 40-р анги 1 удаа, Алтанбулаг сум 1 удаа, Сайхан сум 1 удаа нийт 11 удаа, Ой, хээрийн түймрийн дуудлагаар Зүүнбүрэн суманд 1 удаа, Хүдэр суманд 1 удаа, Алтанбулаг суманд 1 удаа, Ерөө суманд 1 удаа, Цагааннуур суманд 1 удаа, Түшиг суманд 1 удаа нийт 6 удаа, эрлийн ажиллагааны дуудлагаар Сүхбаатар суманд 1 удаа, Жавхланта суманд 1 удаа, Ерөө суманд 1 удаа, Баянгол суманд 1 удаа нийт 4 удаагийн дуудлагаар буюу, нийт 21 удаагийн дуудлагаар ажиллалаа.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар

“Дэлхийн хэмжилзүйн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд Дархан-Уул аймгийн стандартчлал хэмжилзүйн хэлтсийн хэмжилзүйн лабораторитой хамтран лаборатори хоорондын харьцуулалтыг хэмжлийн ажлыг 3 төрлөөр зохион байгуулснаас гадна Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт багш Ц.Төмөрхуяг агсаны нэрэмжит “Аймгийн аварга шалгаруулах хөнгөн атлетик”-ийн тэмцээнийг аймгийн Биеийн тамир, спортын газартай хамтран зохион байгууллаа.

Тайлант сард стандартчилал, тохирлын үнэлгээ, баталгаажуулалт чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Үйлчилгээний баталгаажуулалт: Мандал, Алтанбулаг, Сайхан, Баруунбүрэн, Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар сумын 35 аж ахуйн нэгж, иргэний 37 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, холбогдох стандартын шаардлага хангасан 1 амралтын газар, 4 хүнсний мухлаг, 21 хүнсний дэлгүүр, 7 минимаркет, 2 зоогийн газар, 1 цайны газар, 1 кафений үйлчилгээнд МУ-ын “Худалдааны газар, түүний үйлчилгээ үндсэн шаардлага MNS 5021:2007”, “Хоолны газрын ангилал, зэрэглэл. Үндсэн шаардлага MNS 4946:2005” стандартын шаардлагын дагуу тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олголоо.

Бүтээгдэхүүн баталгаажуулалт: Сайхан, Сүхбаатар сумын 4 аж ахуйн нэгж, иргэний 4 нэрийн 7 бүтээгдэхүүнийг аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн сорилтын лабораторит шинжлүүлж, баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргаж өгсөн байна. Сайхан сумын “Гоё Дэлхий” бялуун бүтээгдэхүүний цехийн үйлдвэрлэж буй 1 нэрийн 12 төрлийн бүтээгдэхүүний хаяг шошгыг хянаж, стандартын шаардлагад нийцүүлэх талаар зөвлөж ажиллав. “Спирт Бал Бурам” ХК-ийн “Evok”, “Аригун”, “Ерөөл” гэсэн 3 нэрийн архины үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаанд “Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалт MNTR 1:2008”-ын шаардлагыг хэрхэн хангаж үйлдвэрлэл явуулж байгаад нь тохирлын үнэлгээ хийж, дээрх бүтээгдэхүүнийг МХЕГ-ын харъяа ХАБУЛ-т хөндлөнгийн лабораторийн сорилт шинжилгээ хийлгэж, түүний үр дүнг үндэслэж тохирлын гэрчилгээ олгохоор шийдвэрлэсэн.

Стандартын салбар сангаас 11 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 9 нэрийн 24 стандартаар хангаж, зөвлөгөө өгсөн байна. Үүнээс 10 ахуй нэгж байгууллага иргэний хүсэлтийн дагуу 8 нэрийн 23 стандартын борлуулалт хийсэн.

Хэмжил зүйн лабораторийн ажил, үйлчилгээг:

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр аймгийн 13 суманд ажиллаж байгаа 42 шатахуун түгээх газрын 129 шингэн хэмжигчийг болон 5 аж ахуйн нэгжийн 6 усны тоолуурыг шалган баталгаажуулах ажлыг хийж, “Буянт рашаан” эмийн сан, “Урсгал Ус” ХХК-ий сорилтын лабораторийн 20 шилэн хэмжүүр, Шүүхийн шинжилгээний албаны 2 уртын хэмжүүрт шалгалт тохируулга, Механик хэмжлийн төрлөөр Сайхан, Баруунбүрэн, Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар сумдын худалдааны газруудын 82 жин 2 туухайг, Алтанбулаг боомт дахь гаалийн газрын 2 автомашины жинг тус тус баталгаажуулсан. Цахилгааны хэмжлийн төрлөөр Сүхбаатар сумын байгууллага

нэгжийн 8 ш цахилгааны 1 фазын тоолуурыг, дулаан, даралтын хэмжлийн төрлөөр “Анар” эмнэлэгийн 2 цусны даралтын аппарат, автоклабны манометр 1ш, “Буянт рашаан” эмийн сан, Баянгол сумын эргэлтийн эмийн сан, Анар эмнэлэг, Содон эмийн сан зэрэг аж ахуйн нэгжийн 12 ширхэг тасалгаа, хөргөгчний термометрыг ээлжит баталгаажуулалтанд хамруулж ажиллалаа.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

2018 оны жилийн эцсийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан гаргахтай холбоотойгоор 2018 онд олгосон санхүүжилтийн дэмжлэг, ОНХС-ийн шилжүүлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийн тооцоог сум, байгууллагаар нь холбогдох яамдтай тооцоог хийж, сумдын төсвийн захирагчдын 2018 оны санхүүгийн тайлан, ОНӨУГазрын тайлангуудыг дуусган аудитын байгууллагын дүгнэлтийг хийлгэн Сангийн яаманд хүргүүлж, санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг шилэн дансанд байршуулж ажиллалаа.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		21.729.227.1	21.061.677.6	96.9
1.1	Орон нутгийн төсвийн орлого	5.341.932.4	4.789.506.9	89.8
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	4.067.717.4	5.082.320.5	124.9
	Сумдын төсвийн орлого	1.274.215.0	1.913847.3	150.2
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	2.031.451.5	2.198.428.7	108.2
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	15.080.692.1	15.025.259.4	99.6
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	1.306.151.0	847.869.2	64.9
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	600.0	600.0	100.
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	131.825.9	131.825.9	100.0
1.7	Төсөвт байгууллагын өөрийн орлого /сум хөгжүүлэх сан орсон/	711.559.2	61.541.3	8.6
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		30.117.597.6	22.952.832.3	76.2
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	30.117.597.6	22.952.832.3	76.2
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	23.484.117.0	19.897.678.1	84.7
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	47.114.0	47.114.0	100.0
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	6.191.744.3	2.653.621.9	42.9
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	600.000.0	74429.3	12.4
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт	249.000.0		
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	1.128.386.4	53.044.2	4.7
	Халамжийн сан	126.557.5	36.000.0	28.4
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	4.087.800.4	2.490.148.4	60.9
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	148.900.0	148.900.0	100.0
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	17.948.520.9	15.699.199.4	87.5
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	441.736.3	401.532.3	90.9
	3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		17.060.594.1	16.494.230.7

3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	5.577.453.6	5.011.090.2	89.8
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	47.114.0	47.114.0	100.0
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	47.114.0	47.114.0	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд			
	Хөрөнгө оруулалтын зардалд	153.500.0	153.500.0	100.0
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	647.255.2	647.255.2	100.0
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	974.886.4	538.255.2	55.2
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	109.000.0	109.000.0	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	11.232.932.9	11.232.932.9	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	203.093.6	203.093.6	100.0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	15.080.692.1	15.080.692.1	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	8.042.231.2	8.042.231.2	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	4.407.613.7	4.407.613.7	100.0
	- Соёлын байгууллага			
	- Биеийн тамир спортын байгууллага			
	- Эрүүл мэндийн байгууллага	2.317.828.2	2.317.828.2	100.0
	- Газрын кадастрын байгууллага	157.757.6	157.757.6	100.0
	- Хүүхдийн байгууллага	155.261.4	155.261.4	100.0
4. Тусгай сангуудын зарлага				
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	711.559.2	61.541.3	8.6

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2018 04- сар	2019 04- сар	2019- 04 2018-04 Х/төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА			
1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
Гурил /савласан, кг/	1 100	1 100	100.0
Талх /орон нутгийн, ш/	1 100	1 200	109.1
Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
Будаа /кг/	2 400	2 400	100.0
Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
Хонины мах /кг/	6 000	9 000	150.0
Үхрийн мах /кг/	7 500	10 000	133.3
Адууны мах /кг/	5 800	8 000	137.9
Ямааны мах /кг/	5500	7 800	141.8
Дотор мах, цувдай /цусгүй/	3500	4 000	114.3
Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
Сүү /задгай, л/	1 500	1 500	100.0
Сүү / савласан, л/	2 600	2 600	100.0
Тараг /задгай, л/	1 800	1 800	100.0
Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	12 000	15 000	125.0
Айраг /л/	3 500	3 500	100.0
Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
Өндөг /ш/	350	350	100.0

4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	3 800	100.0
	Өөхөн тос /кг/	1 500	2 000	133.3
	Шар тос /кг/	15 000	13 000	86.7
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 200	1 000	83.3
	Лууван /кг/	1200	1 200	100.0
	Манжин /кг/	1500	1200	100.0
	Байцаа /кг/	1500	1500	100.0
	Сонгино /кг/	1500	1500	100.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	3 500	100.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	3 000	130.4
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 530	1 645	107.5
	Бензин А - 92	1 735	1 785	102.9
	Дизелийн түлш	2 020	2 330	115.3

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Улсын хэмжээнд явагдаж буй “Зөв тусгал” аяны хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, “Дэлхийн Зөн” Олон улсын байгууллагын Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөр хамтран өртөөчилсөн сургалтыг зохион байгуулж байгаа бөгөөд энэ 5 дугаар сарын 26-ны өдөр Сүхбаатар суманд хийгдэж, сургууль, цэцэрлэгийн багш, эцэг эхийн төлөөллүүд хамрагдлаа.

2019 оны 1 дүгээр улиралд аймгийн хэмжээнд 83 холбогдогчтой, 554.6 сая төгрөгийн хохиролтой, 221 гэмт хэрэг бүртгэгдэж, 69 хэргээр буюу 45.4 хувиар урьд оны мөн үеэс өссөн. Гэмт хэргийн илрүүлэлт 22.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 13.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 5 дугаар сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 405, лавлагаа 4 бичиж, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 145, лавлагаа 29 олгосон. Мөн Иргэний бүртгэлийн үйлчилгээгээр төрсний бүртгэл 206 /эрэгтэй 107, эмэгтэй 99/, гэрлэлтийн бүртгэл 45, гэрлэлт цуцалсны бүртгэл 18, эцэг тогтоолт 52, овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 13, нас баралт 52, нийт олгосон иргэний үнэмлэх 327, шинээр олгосон иргэний үнэмлэх 83, дахин олгосон иргэний үнэмлэх 74, иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан 170, гадаад паспорт олголт 71, ОХУ-ын хил нэвтрэх хавсралт 2768, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 127, хот доторх шилжилт хөдөлгөөн 256-г тус тус бүртгэж, үйлчилсэн.

Архивын чиглэлээр

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 150-р тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 4-р сарын 17-ны А/46 дугаар захирамжийг тус тус үндэслэн “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтөлөлтийн улсын үзлэг”-ийг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг томилж, үзлэгийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор Төрийн албаны зөвлөл, Архивын ерөнхий газрын хамтарсан 2 удаагийн сургалтыг аймгийн төвд зохион байгуулж, 650 гаруй албан хаагчдыг хамруулсан.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албад, төр, төсвийн зарим байгууллагуудын улсын үзлэгт бэлтгэж буй байдлыг газар дээр нь шалган, зөвлөн туслах үүрэг бүхий аймгийн ажлын хэсгийг удирдамжийн дагуу ажиллуулж, хугацаатай үүрэг даалгавар өгснөөс гадна тэдний саналыг харгалзан 5-р сарын 28-ны өдөр Архив зүйн зөвлөгөө өгөх төвийн тэргүүн Дэлгэрцэцэгийг газар,

хэлтэс, албадын архив, бичиг хэргийн эрхлэгч нарт зориулсан сургалтыг хийж, 80 гаруй хүнийг хамруулаад байна.

Тайлант сард Зүүнхараагийн модны үйлдвэрийн хөмрөгийн 1965-1991 оны 101 хадгаламжийн нэгж, Зүүнхараагийн банкны хэлтсийн 1961-1993 оны 53 хадгаламжийн нэгж, Биеийн тамир спортын газрын 1960-2006 оны 190 хадгаламжийн нэгжид тус тус хэсэгчилсэн тооллогыг хийж, иж бүрэн нягтлан шалгалтын ажил болон дансны бүрдэл болох түүхчилсэн лавлах, нэр төрлийн заагуур, хадгаламжийн нэгжийн бүртгэл, баримтын дансны шилжүүлэх хүснэгт, баримтын түүх, ном зүйн жагсаалт, хөмрөгөөс хассан баримтын акт, баримтын түүх, нэрийн өөрчлөлт, цахимд шилжүүлэх баримтын жагсаалт зэргийг боловсруулж ББНШАЗК-ын хурлаар хэлэлцэн баталлаа. Мөн Шаамар сумын МСҮТ-ийн 1978-2000 оны 147 хадгаламжийн нэгжид хэсэгчилсэн тооллогыг хийгээд байна.

Зураг төслийн баримтаар архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх ажлын хүрээнд аймгийн Ерөө сумын Бугант багийн Сургалт мэдээллийн төв мөн тосгоны Шинэ суурьшлын бүс ходоод хэсгийн цахилгаан хангамжийн гүйцэтгэл, Сүхбаатар сумын Могойтын амны хүүхдийн тоглоомын талбайн гүйцэтгэлийн ажлын хувийн хэрэг холбогдох баримт бичгийг хүлээн авч сан хөмрөгт байрлуулж, Сүхбаатар сумын 2, 4 дүгээр цэцэрлэг, “Урсгал ус” ХХК-ийн архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтануудад хадгаламжийн нэгж бүрдүүлэх, данс бүртгэл үйлдэх талаар арга зүйн зөвлөгөө өглөө.

Баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Баруунхараагийн тэжээлийн үйлдвэр, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн хөмрөгийн 17 хадгаламжийн нэгжийн 2034 хуудас баримтын мэдээллийн агуулгыг уншиж заалт-1734, хүний нэр-6720, байгууллагын нэр-1714, газар зүйн нэр-1221-г шивж эх баримттай холбох ажлыг хийж, Биеийн тамир спортын газар, Зүүнхараагийн банкны контор, Найрамдал САА, Шаамар сумын МСҮТ-ийн 52 хадгаламжийн нэгжний 4505 хуудас баримтыг скайнердаж мастер хувь үүсгэсэн.

Иргэд байгууллагын хүсэлтийн дагуу архивын лавлагаа цахим хувиас 104, мастер хувиас 45, цаасан суурьтай баримтнаас 27 тус тус гаргаж өгч ажилласан.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр

БСШУС-ын сайдын 2018 оны 06 дугаар сарын 29-ний А/425 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын хүрээнд 2019 оны 4, 10 дугаар сард хөндлөнгийн үнэлгээний шалгалтыг авахаар төлөвлөж, 04 дүгээр сарын 30-наас 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд шалгалтыг авч, сургууль бүрээр дүн, үнэлгээг нэгтгэн, анализ дүгнэлт гарган ажиллаж байна. Мөн журмын хүрээнд анги дэвших шалгалтын блюпринтийг судлагдахуун бүрээр боловсруулан хүргүүлсэн ба нээлттэй даалгаврын сан бүрдүүлэн, шалгалтад бэлтгэж байна. Улсын шалгалтын даалгаврын санг ашиглан төгсөлтийн шалгалтад бэлтгэх талаар зөвлөн тусалж ажиллаж байна.

Боловсрол, соёл, урлагийн газар үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойг тэмдэглэх ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 30-ны 14 тоот тогтоолын дагуу ажлын хэсгүүдийг байгуулан, төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Аймгийн Нийтийн номын сантай хамтран Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдлэх, ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх зорилгоор үндэсний бичиг үсгийн баярыг “ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСЭГ-ТУСГААР ТОГТНОЛЫН БАТАЛГАА” уриан дор 5-р сарын 06-ны өдөр төрийн болон төрийн бус байгууллагуудын албан хаагчид, ерөнхий боловсролын сургуулиудын багш, сурагчид, иргэдийг оролцуулан “Дээлтэй Монгол” жагсаал, “Өв соёл” ховор номын үзэсгэлэн, “Сайхан бичигтэн”, “Тод түргэн уншигч” шалгаруулах уралдаан, танин мэдэхүйн “Алтан хонх” тэмцээн, монгол бичгийн уран бичлэгийн бүтээлийн үзэсгэлэн зэрэг ажлуудыг зохион байгууллаа. Сүхбаатар сумын 1, 2, 4 дүгээр сургуулийн 4 дүгээр ангийн 11 бүлгийн 330 гаруй сурагч оролцож, “Би хаана төрөө

вэ?”, “Сэлэнгэ мину”, “Миний нутаг” шүлгийг уншиж толилуулж, аймгийн лаборатори 4 дүгээр сургуулийн монгол хэлбичиг, уран зохиолын багш Р.Алтанхүүгийн “Босоо Монголын босго өндөртэй бичиг мину” бийрийн бичлэгийн бүтээлийн үзэсгэлэнг 05 дугаар сарын 03-ны өдөр нээлээ. Үзэсгэлэнд бийрийн бичвэрийн 100 гаруй бүтээлийг дэлгэн үзүүлж, бичиг үсгийн соёлыг сурталчилж, түгээн дэлгэрүүлж байна. БСШУСЯ-ны шагналын журмын дагуу “Үндэсний бичиг, соёлыг дэлгэрүүлэгч” тэмдгээр боловсролын салбарт олон жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж, үндэсний бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулж байгаа 9 багшийг шагнаж урамшуулсан бол монгол хэлбичиг, уран зохиолын хичээл зааж байгаа багш нарын туршлага судлах үзүүлэх ажил, сургалтыг 05 дугаар сарын 09-нд Түшиг суманд зохион байгуулж, 39 багшийг оролцууллаа. Монгол бичгийн сургалт, судалгааны “Ертөнц” төвөөс зохион байгуулдаг “Үндэсний өв соёлоо тээгч, түгээгч 2019” улсын уралдаанд 6-10 дугаар ангийн 11 бүлгийн 300 гаруй сурагчийг амжилттай оролцууллаа.

Боловсролын салбар дахь залуу, дунд, ахмад үеийн залгамж холбоог бэхжүүлэх, залуу багш, удирдах ажилтнуудын ажлын дадлага туршлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2017 оны А/255 тоот захирамжаар байгуулагдсан “Ахмадын зөвлөх үйлчилгээний баг”-ийг 2019 оны 5-р сарын 06-наас 10-ны өдрүүдэд Ерөө бүсийн сургууль, цэцэрлэгүүдэд ажиллууллаа.

Төрөлжсөн хичээлийн Улсын олимпиадад багш сурагчдаа оролцуулах бэлтгэлийн ханган ажиллаж, улсын уралдаанд оролцогчид дараах амжилтыг гаргалаа. Үүнд:

Багш нараас:

Сайхан сумын ЕБС-ийн багш Э.Оюун-Эрдэнэ орос хэлний улсын олимпиадаас алтан медаль, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн багш М.Баасанхүү газарзүйн улсын олимпиадаас мөнгөн медаль

Сурагчдаас:

Мандал ЕБ-ын 3 дугаар сургуулийн сурагч Хишигбаярын Баттулга технологийн олимпиадын авто загварын төрлөөр алтан медаль, Сүхбаатар сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 11 дүгээр ангийн сурагч Батдоржийн Билгүүн сэтгэх чадварын улсын олимпиадаас мөнгөн медаль, Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн сурагч Баттогтохын Билигсайхан технологийн улсын олимпиадаас мөнгөн медаль, Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн сурагч Хадбаатарын Манлайбаатар технологийн олимпиадаас усан загварын төрлөөр мөнгөн медаль тус тус хүртсэн.

ХАБЭА-ын сарын аян 2019” арга хэмжээг “Эрүүл аюулгүй ирээдүйн хөдөлмөрийн төлөө” уриан дор 2019.04.18-2019.05.08-ны хооронд Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын 34 сургууль, 42 цэцэрлэгт амжилттай хэрэгжүүлэн зохион байгууллаа. Сургууль, цэцэрлэгүүд ХАБЭА-ны төлөвлөгөөг жилийн ажлын төлөвлөгөөнд тусган ажиллаж хэвшсэн байгаа нь тайлангаас харагдаж байгаа ба тусгагдсан ажлуудыг нэгтгэвэл: Сургуулийн 3069 багш, ажилчид 12600 сурагч, 2973 эцэг эх нийт 18642, цэцэрлэгийн 1369 багш, 1600 сурагч, 2973 хүүхэд нийт 5942 бүгд 24584 хүнийг хамарсан сургалт, сурталчилгаа, үзүүлэх ажил, туршилт, дадлага хийх, “Газар хөдлөлт болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх” дадлага ажил болон анхан шатны тусламж үзүүлэх бэлэн байдлын сургуулилтыг зааварчилгаа өгөх ажлууд хийгдсэн байна.

“Өсвөр үеийн эрүүл мэнд ба бэлгийн эрүүл мэнд” сэдвээр мэдээлэл боловсруулан, сургуулиудад хүргүүлж, эмч нараар 5619 сурагч, 2439 эцэг эхэд сургалт зохион байгуулуулж, 11 сургууль 1227 охид, 288 хөвгүүдийн эрүүл мэндийн үзлэгт хамруулж, гарын авлага тарааж, яриа хийсэн байна.

Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд ЕБС-иуд Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 4 дэх шатны төслийн санал бичиж хүргүүлэх ажил өмнөх сард хийгдэж, БСШУСЯ-д хүргэгдсэн бөгөөд төслийн шалгаруулалтын дүн гарч БСУГ

болон 14 сургуулийн нийт 236,515,500 сая төгрөгийн 15 төсөл батлагдсан. Үүнийг сургуулиудад мэдэгдэж, улмаар 5 дугаар сарын 24-ний өдөр эдгээр сургуулийн захирлууд БСУГ-ын даргатай төсөл хэрэгжүүлэх гэрээ байгууллаа. Төслийг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлнэ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, “Боловсрол” телевиз хамтран ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багшийн ажил, мэргэжлийн онцлогийг нийгэмд таниулах, шилдэг арга зүй, ур чадвартай манлайлагч багш нарыг урамшуулан дэмжих, багш мэргэжлийн нийгмийн үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилготой “Би багш” уралдаант шоу нэвтрүүлгийг зохион байгуулж байгаа бөгөөд аймгийн ерөнхий боловсролын 34 сургуульд удирдамжийг хүргүүлэн, багш нарт мэдээллийг хүргэж, шоу нэвтрүүлэгт оролцуулах талаар сургуулийн удирдлагуудад чиглэл өгч ажиллалаа. Нэгдүгээр шатны уралдааныг 05 дугаар сарын 08-ны дотор зохион байгуулж, Бодлого хэрэгжилтийн албаны дарга Ч.Алтантуяа, бага боловсролын мэргэжилтэн П.Мягмарсүрэн, математик, мэдээллийн технологийн боловсролын мэргэжилтэн Д.Нарантуяа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Боловсрол, соёл, урлагийн газарт ирүүлсэн бичлэгүүдийг үзэж, 5Р шалгуур үзүүлэлтийн дагуу 2 дугаар шатны уралдаанд оролцуулахаар дараах 3 багшийн бичлэгийг шалгаруулан танилцуулгыг бэлтгэн хүргүүлэв.

Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд ЕБС-иудад Ангийн номын сангийн 2 дахь хэсгийн 991 ширхэг номыг түгээж Боловсролын салбарын мэдээллийн системд бүртгэлийг орууллаа.

Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд бага боловсролд нийлүүлэгдсэн СТЕМ сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалт, хичээл зохион байгуулалт, ололт амжилтын талаар багш сурагчидтай бүлгийн ярилцлага хийж, судлан багш нарын хичээлд ажиглалт хийж, дүгнэлт хийх зорилготойгоор БСШУСЯ-ны удирдамжийн дагуу БМДИ-ийн арга зүйч Булгантамир ирж Сүхбаатар 2, Шаамар, Ерөө, Алтанбулаг сумдын сургуулиудад ажиллав.

2019-2020 оны хичээлийн нэгдүгээр элсэн суралцах хүүхдийн судалгаа гаргаж БСШУСЯ-ны Ерөнхий боловсролын бодлогын газарт хүргэсэн. Судалгаагаар ирэх хичээлийн жилд 2364 зургаан настай хүүхэд элсэн суралцахаас 71 бүлэгт 2282 хүүхэд бүртгэгдсэн байна.

Цэцэрлэгийн эрхлэгч нарт мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулж, 2018-2019 оны хичээлийн жилд 26 эрхлэгч “Заах аргач”, 1 эрхлэгч “Тэргүүлэх” зэргийг олгуулахаар материалыг бүрдүүлэн хянаж, дүгнэлтийг хүргүүлээд байна.

Соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, эрхзүйн орчныг танилцуулах, туршлага солилцох зорилгоор сумдын соёлын ордон, соёлын төвүүдийн эрхлэгч, орон нутаг сурталчлах танхимын ажилтнуудад зориулсан **“Соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах нь”** сургалтыг 4-р сарын 26-ны өдөр Баруунбүрэн сумын Соёлын төвд зохион байгууллаа. Сургалтад 19 соёлын төв, 1 соёлын ордны эрхлэгч, орон нутаг сурталчлах танхимын ажилтан нийт 37 хүнд оролцож, “Удирдах ажилтны улсын зөвлөгөөний шийдвэр, цаашид анхаарах асуудлууд”, “Соёл, урлагийн салбарын цаг үеийн мэдээлэл”, “Музей менежментийн ба хууль эрх зүйн үндсүүд”, “Бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх арга зүй”, сан хөмрөгч “Үзмэрийн зохистой орчин түүний бүрдлүүд” сэдвээр илтгэл, мэдээлэл тавьсан.

Сэлэнгэ аймагт Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн төрийн захиргааны байгууллага үүсч хөгжсөний түүхт 60 жилийн ойг баярыг угтан ахмад багш нарын авъяас чадварыг дэмжих, сурталчлах, залуу үеийнхэнд үлгэр дууриал үзүүлэх зорилгоор УИХ-н гишүүн Н.Оюундарийн ивээл дор ахмад багш нарын анхдугаар “Урлагийн их наадам”-ыг зохион байгуулж байна. Наадам гоцлол, хамтлаг болон дуэт дуу, гоцлол, хамлаг бүжиг, гоцлол хамтлаг хөгжим гэсэн 7 төрлөөр 2 үе шаттай зохион байгуулагдсан бөгөөд эхний шатны шалгаруулалт бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулагдаж дээрх 7 төрлөөр бүс бүрээс шалгарсан 70 гаруй ахмад багш 4-р сарын 28-нд төгсгөлийн шатны шалгаруулалтанд оролцлоо. Уралдааны төрөл бүрээс эхний 3 байрыг, бүсийн нийлбэр оноогоор “Шилдэг баг”-г шалгарууллаа. “Шилдэг баг”-р Бэлчир бүсийн ахмад багш нар шалгарлаа.

АДБ-ын “Сэлэнгийн долгио чуулга”-ын ажилчдын ур чадварын түвшин тогтоох шалгалт 5-р сарын 02-ны өдөр болж, шалгалтанд Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургуулийн захирал Ганцэцэг, уртын дууны багш Цогтсайхан, Бүжгийн урлагийн сургуулийн багш Гэрэлтуяа нарын бүрэлдэхүүнтэй шүүгчдийг урин 4 хөгжимчин, 11 дуучин, 7 бүжигчин нийт 22 уран бүтээлч хамрагдлаа.

Сэлэнгэ аймагт боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн төрийн захиргааны байгууллага үүсч хөгжсөний 60 жилийн ойн хүрээнд “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын Сэлэнгэ нутгийн хөтөлбөрийн газартай хамтран зорилтот сумд болох Шаамар, Жавхлант, Ерөө, Хүдэр, Орхон, Сант, Сүхбаатар сум, Дулаанхаан, Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулиудын дуу хөгжмийн хичээлийн сургалтыг чанаржуулж, өсвөр үеийнхэнд уран сайхны боловсрол олгож, гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх, эрсдэлд буй хүүхдийн авьяас чадварыг шинээр нээж тэднийг урлаг соёлоор дамжуулан төлөвшүүлэх зорилгоор “Зөнгийн одод-Миний эх орон” сэдэвт хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг шалгаруулах уралдааныг 2019 оны 5-р сарын 17-ны өдөр Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио чуулга”-ын байранд амжилттай зохион байгууллаа.

2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар

2019 оны 04-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 821 байсан бол 393 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 212 ажлын байранд 107 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 354 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 753 болсон байна.

Нийгмийн халамжийн сангаас 5 дугаар сарын байдлаар 37,112 иргэнд 6,510,532.146 мянган төгрөгийг олгоод байна.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний хүрээнд Сүхбаатар сумын 1,2,3,4,5,6-р сургууль, Алтанбулаг, Жавхлант, Хүдэр, Шаамар сумд, Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 9-12-р ангийн 29 бүлгийн 825 сурагчдад “Мэргэжил бүхэн сайхан” сургалтыг амжилттай зохион байгууллаа. Шаамар сумын МСҮТөвд суралцагч 33 иргэнд “Амжилтын гараа” сургалтыг зохион байгуулсан.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэний хүсэлтийг хүлээн авч тус газрын төсөл сонгон шалгаруулах комиссын хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, 49 иргэнийг дэмжин ХЭДСангаас 224000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож, 50 ажлын байрыг шинээр бий болгож баталгаажуулан тэдгээр иргэдийн үйл ажиллагааг тогтвортой явуулах боломжийг олгож, өрхийн орлогыг нэмэгдүүллээ.

“Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар”-аас эрх авсан Дархан-Уул аймгийн “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв”-тэй хамтран Орхон, Сант сумдын 40 иргэнийг Бизнес төсөл боловсруулах 3 хоногийн сургалтанд хамруулж, 600.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд Мандал суманд нийтийн эзэмшлийн талбайн тохижилтын ажилд 7 иргэнийг түр ажлын байраар хангаж ХЭДСангаас 1400.0 мянган төгрөгийг цалин болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардалд зарцуулсан.

Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд иргэдийг 24 бүлэг болгон хамруулж, ХЭДСангаас 29500.0 мянган төгрөгийн хүнсний ногоо тариалахад шаардагдах үр бордоо, тоног төхөөрөмж, бусад үйл ажиллагааны зардалд зарцууллаа.

"Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний хүрээнд Мэргэжлийн чиг баримжаа олгох нийгэмшүүлэх, анхан шатны мэдлэг олгох сургалтанд Сүхбаатар сумын хөгжлийн бэрхшээлтэй 26 иргэдийг хамруулж, 1820.0 мянган төгрөгийг зарцууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт Баянгол, Алтанбулаг, Мандал, Сант, Цагааннуур, Сүхбаатар, Орхон, Хүдэр сум Хэрх, Түнхэл, Бугант тосгонд гар утас засвар, худалдаа үйлчилгээ, цахилгаан бараа засвар, шүрэн эдлэл хийх, гэрийн мод, талх үйлдвэрлэл, эмийн ургамал хатааж боловруулан

савлах, зөгийн аж ахуй, мал аж ахуй болон тахиан аж ахуй эрхлэх зэрэг чиглэлээр 13 төслийг дэмжин хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 52000.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Үүний үр дүнд шинээр 13 ажлын байр бий болгон ажиллалаа.

3.Эрүүл мэндийн талаар

“Лаборант нарын мэдлэг ур чадварыг сайжруулах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, сум, тосгодын Эрүүл мэндийн байгууллагын нийт 24 лаборантыг 2 өдрийн сургалтанд хамруулсан. Сургалтаар ёс зүй, харьцаа хандлага болон лабораторийн ажлын байрны тодорхойлолт, био аюулгүй ажиллагаа, халдварт өвчний шинжилгээний оношлогоо, лабораторийн шинжилгээний чанарын хяналтын талаархи мэдлэг, хандлагыг нэмэгдүүллээ.

Глобаль сангийн төслийн зохицуулагч н.Цогзолмаа ахлагчтай баг аймгийн Нэгдсэн мэнэлэг, Эмнэх Өрхийн эрүүл мэндийн төвд ажиллалаа. Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй Эрүүл мэнд хөгжил хөтөлбөр 5 төсөл манай аймагт хэрэгжлээ. Тус төслийн дагуу 4 зорилт бүхий арга хэмжээ аймгийн Нэгдсэн эмнэлэгт хэрэгжиж нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан.

Дулаанхаан тосгонд халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, иргэдийн эрүүл мэндийн мэдээллийн цахим сан бий болгох үзлэг, оношилгоог зохион байгуулж сум, тосгон өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт 1 өдрийн сургалтыг зохион байгуулж, 5 бүс болгон хувааж Эрүүл мэндийн газраас мэргэжилтнүүдэд хариуцуулан уралдаан зарлаж ажиллаж байна. Улаанбурхан, улаануудын эсрэг вакцины хамрагдалт аймгийн хэмжээнд 2019.05.20-ны байдлаар 84,1 хувьтай байна. Рашаант, Номгон тосгоны эрүүл мэндийн төвүүд нэмэлт дархлаажуулалтаа 100 хувьд хүргээд байна

Нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамрагдсан залуучуудын дунд 604 өвчлөлийг шинээр илрүүлэн эмчийн хяналтанд авч, онош тодруулах эмчилгээ хийлгэх шаардлагатай 291 залууг лавлагаа шатлалын эмнэлэгт, 138 залууг төрөлжсөн төв эмнэлгүүдэд шилжүүлж, мэс заслын хагалгаанд орох шаардлагатай 142 залуу байна.

2019 оны 4-р сарын 19-нөөс 5-р сарын 03-ныг хүртэлх хугацаанд дахин сонгон шалгаруулалтыг зарласан ба 5 өрхийн эрүүл мэндийн төв материал өгч ажиллаа. Мандал болон Сүхбаатар сумын хүн амд өрхийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх сонгон шалгаруулалтанд Сүхбаатар сумаас өрхийн эрүүл мэндийн төвийн 3 баг, Мандал сумаас өрхийн эрүүл мэндийн төвийн 2 баг материал бүрдүүлэн оролцлоо. Үүнд:

-“Хараа Манал” өрхийн эрүүл мэндийн төвийн баг 118,1 оноо авч 98,3%

-“Үйлст Эмнэхүй” өрхийн эрүүл мэндийн төвийн баг 113,4 оноо авч 94,5%

-“Ачит-Амирлуулагч” өрхийн эрүүл мэндийн төвийн баг 117 оноо авч 97,5%

-“Номтхан” өрхийн эрүүл мэндийн төвийн баг 125 оноо авч 96%

-“**Эмнэх баг**” өрхийн эрүүл мэндийн төвийн баг 119,5 оноо авч 92 хувьтай дүгнэгдсэн.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулж нийт 408 иргэдэд үйлчилгээ үзүүлж, 380 ширхэг тараах материал, гарын авлагыг хүргүүлснээр иргэд олон нийтийн хууль, эрх зүйн мэдлэг дээшилж, сэтгэлзүйн үйлчилгээ нэн шаардлагатай 33 хүнд анхан шатны үйлчилгээг үзүүлж, зорилтот бүлгийн 6 залууг байнгын болон түр ажлын байранд холбон зуучилж, санал хүсэлтийн хайрцгаар 67 хүний саналыг хүлээн авч, мэдээ мэдээллээр ханган салбарын болон байгууллагын үйл ажиллагааг сурталчлан ажилласан үр дүнтэй байлаа. “Хүүхдийг зодож шийтгэхгүй байх өдрийг” угтан “Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэе” уриалга гарган ажилласан.

“Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аяныг 4 дүгээр сарын 15-аас 5 дугаар сарын 15-ны хооронд бүх сум, тосгодод зохион байгууллаа. Аянд 36 сургуулийн 9 дүгээр анги болон ахлах ангийн 1624 өсвөр үе, залуучуудыг хамруулж, мэргэжил сонголттой холбоотой шторкуудыг хувийн болон байгууллагын цахим хуудаснаа

сурталчиллаа. Бүсчилсэн хэлбэрээр 1 мини аялал, 17 удаагийн сургалтаар 1624 хүүхдийг сургалт лекцэнд хамруулж, экспо өдөрлөгийг зохион байгууллаа.

Зорилтот бүлгийн залууст амьдрах ухааны боловсрол олгох модуль сургалыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Төлөвлөгөөний дагуу Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 34 оюутанд "Хорт зуршил болон донтолтоос сэргийлэх нь", "Стрессээ даван туулах уур бухимдлаа барих нь" сэдвүүдээр сургалтыг зохион байгууллаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт ял эдэлж буй 13 залууст "Стрессээ даван туулах нь", "Өөртөө итгэх итгэл, амлалтаа биелүүлэх нь" зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулж, сэтгэл зүйчтэй хамтран хүн тус бүрт ганцаарчилсан зөвлөгөө өгч ажиллалаа.

"Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд 15-34 насны ажилгүй болон ажил идэвхтэй хайж байгаа мөн их дээд сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчид болон төгсөгчдөд зориулсан "СТАР АП" арга хэмжээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран зохион байгуулахаар төлөвлөн 36 залууг "Бизнес эрхлэгч гэж хэн бэ?", "Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах нь", "Бизнесийн хуулийн хэлбэр", "Хуулийн хариуцлага ба даатгал", "Ажиллах хүч, гарааны хөрөнгө ба эх үүсвэр", "НББ, санхүү төлөвлөлт", "Маркетинг болон зах зээлийн судалгаа" зэрэг хичээлүүдийг багтаасан 72 цагийн сургалтанд хамруулж Олон улсын "БЭ-БХ" хөтөлбөрийн аж ахуй эрхлэлтийн мэргэшсэн чадамжийн гэрчилгээг гардуулаад байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны 03 дугаар сарын 28 ны өдрийн А\41, А\51 тоот хамтарсан тушаалын дагуу Сүм хийдийн дэргэдэх сургалтын байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж аймгийн хэмжээнд 39 сүм хийд байгаа ба үүнээс зөвшөөрөлгүй 9, шарын шашны урсгалтай 5 хийд тус тус үйл ажиллагаагаа явуулж байна. Баруунбүрэн сумын ЕБС –ийн нийгмийн ажилтны гомдол мэдээллийн дагуу тус сумын 1 дүгээр багийн иргэн Ц-д Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 1.3 дэхь хэсэгт заасныг үндэслэл болгон зөрчлийн хэрэг нээж шийдвэрлэсэн. Мөн нэг гомдол мэдээллийг харьяалалын дагуу Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 13 хүүхдэд хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулж холбогдох мэдээллийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлсэн. Шаамар, Баруунбүрэн сумд, Сүхбаатар сумын 4-р баг, аймгийн Татварын хэлтэст "Хүүхэд хамгааллын өнөөгийн нөхцөл байдал цаашид анхаарах асуудал" сэдвээр сургалт мэдээлэл хийж давхардсан тоогоор 200 гаруй иргэд хамрагдсан. Насанд хүрээгүй 4 хохирогчийн хууль ёсны төлөөлөгч томилон тэдний эрх ашгийг хамгаалан оролцсон. Жавхлант сумаас алга болсон У охиныг эрэн сурвалжлах ажлын хүрээнд хүүхдүүдээс асуумж авч нэгтгэн дүн шинжилгээ хийж аймгийн Цагдаагийн газарт хүргүүлсэн. Гэмт хэрэгт холбогдсон иргэн Н-ыг хүүхдийн хамт түр хамгаалах байранд байршуулах, байцаалтанд ороход хүүхдийг нь харах, хүүхдүүдийг нь асран хамгаалагчид хүлээлгэн өгөх, эд материалын тусламж үзүүлэх, эмчид үзүүлэх зэрэг арга хэмжээг авч ажилласан.

Монгол оронд Хүүхдийн хөдөлгөөн, байгууллага үүсч хөгжсөний 94 жилийн ойг угтан "Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга" аяныг өрнүүлж Замын цагдаагийн газартай хамтран "Хүүхдийн тусламжийн 108 утасны Хүүхдээ хамгаалъя", "Хүүхэд хүмүүжлийн эерэг аргад суралцъя" 2 төрлийн 3200 ширхэг стикерийг тээврийн хэрэгслүүдэд нааж, жолооч зорчигчдод хүүхэд хамгааллын чиглэлээр сэрэмжлүүлэг түгээж, иргэдэд "Хүүхэд хүмүүжлийн эерэг аргад суралцъя" сэдэвт сургалт зохион байгууллаа.

Аймгийн хурдан морины хаврын бүсийн уралдаанд уралдаанч хүүхдийн эрх ашгийг хамгаалах, эрүүл мэнд аюулгүй байдалд хяналт тавьж, хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллалаа. Уралдаанд 9 насны 378 морь уралдаж, нийт давхардсан тоогоор 167 уралдаанч хүүхэд оролцсон. Шаамар, Сүхбаатар сумын иргэдэд "Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга", "Хүүхдийн хөдөлмөр", "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ыг сурталчлан таниулах сургалт мэдээллийг зохион байгууллаа. Сургалтанд 200 гаруй хүн хамрагдсан.

“Хүүхдийн хүмүүжил төлөвшил” сургалтыг Сүхбаатар сумын 2 сургуулийн 8 дугаар ангийн 46 хүүхдэд зохион байгуулсан.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд нийт 6 дуудлага ирж хамтарсан багийн хариу үйлчилгээ үзүүлээ. Дуудлагыг хүүхдийн эсрэг хүчирхийллийн төрлөөр ангилбал:

- Бие махбодын хүчирхийлэл – 2
- Үл хайхрах хүчирхийлэл – 1
- Сэтгэл санааны хүчирхийлэл – 2
- Бэлгийн хүчирхийлэл – 1

Гэр бүлийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан 270 өрх бүрт хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу урьдчилсан байдлаар нийт 88 өрхийн 195 насанд хүрэгч, 148 хүүхдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж ажиллаа. Үүнд:

“Зөв тусгал” хүүхэд хамгааллын аяны хүрээнд “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Хүүхдийн сэтгэл зүйн онцлог” сэдэвт сургалтыг Сүхбаатар сумын 4 дүгээр баг, Шаамар сумын төрийн албан хаагчид, иргэд олон нийтэд зохион байгууллаа. Нийт 362 хүн хамрагдсан. Гэр бүлийн гишүүдийн тэгш оролцоо, үнэт зүйлсийг бэхжүүлэх, гэр бүлийн бат бэх тогтвортой байдлыг хангах, хүүхдийн эрхийг дээдэлж гэр бүлийн хөгжлийг дэмжих замаар тэдний орон нутгийн хөгжилд оролцох оролцоог дээшлүүлж **“ГЭР БҮЛИЙН АЗ ЖАРГАЛ-ҮНЭ ЦЭНЭ”** хүндэтгэлийн арга хэмжээнд 17 сум 6 тосгоны нийт 104 гэр бүл оролцож, урилгаар Улаанбаатар Их сургуулийн лектор багш “Аз жаргалтай гэр бүл” лекц уншиж, хүндэтгэлийн арга хэмжээнүүд зохион байгуулагдсан. 17 сум 6 тосгоны шилдэг гэр бүлүүдийг 9 номинациар шалгаруулж нийт 53 шилдэг гэр бүл хамрагдснаас:

1. Алтанбулаг сумын Б. Бат-Эрдэний гэр бүл “Угийн бичигтэн” гэр бүл
2. Сүхбаатар сумын Д. Нямсүрэн “Эрүүл мэндийг дэмжигч” /ээлтэй/ гэр бүл
3. Мандал сумын Д. Ганболд “Эко орчин бүрдүүлэгч” гэр бүл
4. Шаамар сумын Д. Баттөмөр “Хөдөлмөрч” гэр бүл
5. Хүдэр сумын Н. Цогнэмэх “Залуу малчин” гэр бүл:
6. Сант сумын Б. Цэвээнжав “Манлайлагч” гэр бүл
7. Сайхан сумын М. Чулуун-Эрдэнэ “Бахархан дууриах” гэр бүл
8. Мандал сумын Т. Отгонбаатар “Үр хүүхдээ зөв төлөвшүүлсэн” залуу гэр бүл
9. Бугант тосгоны М. Мөнхбат “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн” гэр бүлээр тус тус шилдэг гэр бүлээр шалгарч, батламж, гарын бэлгээр шагнагдлаа.

“Монголын хүүхдүүд” хүүхдийн урлагийн их наадмын төвийн бүсийн шалгаруулалт Дархан-Уул аймагт зохион байгуулагдаж наадамд 300 орчим хүүхдүүд 14 төрлөөр оролцсоноос тус аймгийн авьяаслаг хүүхдүүд 4 төрөлд 15 номер үзүүлж, Мандал сумын “Нарны домог” хамтлаг улсад оролцох эрхээр шагнагдлаа. Нийт 58 хүүхэд, 9 багш оролцосон.

5. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

2019 оны 5-р сарын байдлаар 12.05 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 5-р сарын 24-ний байдлаар өссөн дүнгээр 12.95 тэр бум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 107,41 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 16688 тэтгэвэр авагчдад 22962.49 сая төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 2651 хүнд 1004.99 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 246 хүнд 746.84 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 181 хүнд 250.46 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор 2019 оны 05 сард нийт 5 хурал хийж 374 хүнээс, 18 хүнийг цуцалж, 29 хүн шинээр тогтоолгосон, 327 хүн актаа сунгуулсан байна. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг 05 сард 604 иргэд, даатгуулагчдад гарган үйлчилсэн.

Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Тэтгэмж тогтоолт, олголт, сангийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн үндэслэлийг шалгах тухай” А/20 тоот тушаалын дагуу аймгийн хэмжээнд 90 хоногийн хугацаанд шалгалтыг явуулж мэдээллийн технологийн төвөөс түүврийн судалгаагаар гаргасан Хөдөлмөрийн чадвар алдалтын 3106 даатгуулагч, мөн жирэмсэн амаржсаны 1186 даатгуулагчийн 2017 оны 01 сарын 01-нээс 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааг хамруулан зааврын дагуу тэтгэмжийн програм нийгмийн даатгалын лавлагааны програм HIS програм болон эмнэлгийн хуудсанд бичигдсэн овог нэр, регистрийн дугаар, эмнэлгийн хуудас засвартай бичигдсэн эсэх, эмнэлгийн хуудасны эхлэх огноо программд үнэн зөв орсон эсэх зэргийг тулган шалгасан.

Жирэмсэн амаржсаны 215 даатгуулагчийн материалыг шалгахад: Тэтгэмж тооцсон цалин, эрх нь тулсан 12 сартай 6 даатгуулагч тэтгэмж тооцсон цалин, эрх нь тулсан 6 сартай 80 даатгуулагч тэтгэмж тооцох цалинд өөрчлөлт орсон 117 даатгуулагч зөвхөн амаржсаны тэтгэмж авсан 12 даатгуулагч баримтыг шалгахад аймгийн хэмжээнд цалингийн дундажийг буруу тооцсон 5 даатгуулагчийн 404038 төгрөгийн зөрчил, тэтгэмжийн эрх үүсээгүй 7 даатгуулагчийн 2287974 төгрөгийн зөрчил илрэн нийт 2692012 төгрөгний тэтгэмжийг буцаан төлөхөөр акт гарсан байна.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

“Адра Монгол” ОУБ-ын “Органик хөдөө аж ахуйн түншлэл” төсөлтэй хамтран “Органик хөдөө аж ахуй хамтын баталгаажуулалтын сурагч багш бэлтгэх сургалт”-ыг 5 дугаар сарын 22, 23-нд өдрүүдэд 120 гаруй хүнийг хамруулан зохион байгуулж, органик хөдөө аж ахуйг хөгжүүлсэн туршлага, мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх боломж, орон нутгийн иргэд, хоршоонд суурилсан органик хүнсний хамтын баталгаажуулалтын байгууллагын удирдлага, зохион байгуулалт, органик бүтээгдэхүүний баталгаажуулалт, нэмүү өртгийн сүлжээний талаар цогц мэдлэгийг олголоо.

Сум хөгжүүлэх сангийн улсын үзлэгийг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар томилж, үзлэгийг 5-р сарын 15-наас 25-ны өдрүүдэд бүх сумдыг хамруулан явуулж, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтэнд санал дүгнэлт гаргаж, цаашид авах арга хэмжээ, төлөвлөгөө, санал, зөвлөмжийг боловсруулан, нэгтгэж дуусгалаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны 5 дугаар сарын 24-ний А/200 тоот захирамжаар төсөл сонгон шалгаруулах дэд хороог байгуулан Жижиг дунд үйлдвэрийн төсөл болон жижиг дунд үйлдвэр эрхлэгчээр бүртгүүлэхтэй холбоотой мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна.

“Бог малд ангилалт хийж, ашиг шимийн гарц чанар, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, төлөв байдлын үнэлгээ хийх” ажлыг эхлүүлсэн бөгөөд энэ сарын байдлаар 33500 хонь, 17100 ямааг хамруулаад байна.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

2019 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 48 ажил, төсөл арга хэмжээ нийт 46798,2 сая төгрөгийн санхүүжилт олгогдохоор батлагдаж, 21 ажлыг зохион байгуулах эрх аймагт шилжин ирснээс 20 ажлын тендер зарлагдаж, 12 ажлын гэрээ байгуулагдан, 2 ажил бүрэн дуусаад байна.

Аймгийн Орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгө оруулалтаар нийт 56 ажил батлагдаж, 2 ажил эрх шилжүүлж, 26 ажлын тендер зарлагдаж 12 ажлын гэрээ байгуулагдаж, 6 ажил бүрэн дуусаад байна.

Тайлант сард аймгийн Засаг даргын 8 удаагийн захирамжаар нийт 32 иргэний газар эзэмших эрхийг шилжүүлж, 2 иргэний эзэмшил газрыг нэгтгэж, 3 иргэний газар эзэмших эрхийг баталгаажуулан хуулийн хугацаанд өргөдлийг шийдвэрлэв. Мөн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д зааснаар 43 иргэн, 3 аж ахуйн нэгж, 1 төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээнд

Э дугаар авах хүсэлтийг дундын мэдээллийн сангаар дамжуулан Улсын бүртгэлийн хэлтэст илгээж, 22 иргэн, 3 аж ахуйн нэгжид газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулан газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэлээ.

Аймгийн хамгийн нам дор газрыг тодорхойлох ажлын хүрээнд 2019 оны 05 сарын 23-ны өдөр хэмжилт хийж 592.6 м өндрийг тогтоон баталгаажууллаа.

МУ-ын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу “ Иргэн хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийсэн эсэх” сэдэвт нийцлийн аудитын удирдамжийн дагуу Сүхбаатар сумын инженерийн шугам сүлжээнд хамаарах 2015-2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, төлөвлөгөөний дагуу газар олголт хийгдсэн эсэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлсэн, ашиглуулсан дуудлага худалдаа төсөл сонгон шалгаруулалтаар олгосон байдал, газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэл хөтөлөлт, нэгж талбарын хувийн хэрэг үүсгэж архивласан байдал, газрын зөрчил маргаан шийдвэрлэлт, газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн программ хангамжийн ашиглалтын байдлын талаар аймгийн аудитын хэлтсийн ажлын хэсэгт шалгуулж холбогдох тайлан судалгаа, мэдээг хэвлэмэлээр, файлаар baasansuren.0119@gmail.com хаягаар тус тус дурьдсан хугацаанд хүргүүлж ажиллав.

Долоо. Байгаль орчны чиглэлээр

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал, аймгийн Засаг даргын “Хяналтын цэг ажиллуулах тухай” А/86 дугаар захирамжийн дагуу “Байгалийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох” зорилгоор Хүдэр сумын нүхэн гүүр, Ерөө сумын Ялбаг, Могойн даваа орчимд цагдаагийн газартай хамтран Байгаль орчны хяналтын постыг ажиллуулж байна.

“Бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын А/156 тоот захирамж, бүх нийтээр мод тарьсан дүн мэдээг авах хүснэгтийн хамт 17 сум 6 тосгонд явуулсан. Бүх нийтээр мод тарих өдрөөр аймгийн хэмжээнд 18102 ш модыг, 3449 иргэн, 377 аж ахуйн, нэгж байгууллага тарьж арчилсан байна. Бүх нийтээр мод тарих ажилд 52,58100 төгрөгийг зарцуулсан.

Хууль бусаар ан амьтан агнах, барих үйлдлийг таслан зогсоох, иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, БОАЖГ-ын дарга нарын баталсан “Хавар” нэгдсэн арга хэмжээний удирдамжийг боловсруулан сумдад хүргүүлсэн. Мөн Миний Монгол, Таны телевизээр агнуурын амьтныг хуулиар хориглосон хугацаанд хууль бусаар агнах, барихыг зогсоох тухай сэрэмжлүүлэгбүхий шторк явуулсан. НҮБ-ын ХХАА-н “Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлыг хамгаалах тогтвортой ойн менежмент, нүүрстөрөгчийн хийн хуримтлалыг нэмэгдүүлэх төсөл”-тэй хамтран Алтанбулаг сумын ойн санг гэрээгээр эзэмшигч 6 нөхөрлөлд зэрлэг амьтны мониторинг судалгаа хийх арга зүй, агнуурын бүс нутаг эзэмших тухай сургалтыг зохион байгуулахад 18 гишүүн хамрагдсан. Ойгоос мод бэлтгэсэн 26 аж ахуйн нэгж байгууллага, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүд 413.5 га талбайд өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийсэн байна.

Байгаль орчны чиглэлээр гарсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор хяналт шалгалтын ажлуудыг зохион байгуулж байгаа бөгөөд тайлант сард Баянгол сумын Урт булагийн ам гэх газарт MV-020859 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Тайхаржин майнинг” ХХК-д 10,0 сая төгрөгийн торгууль, “Баян өгөөж хараа” нөхөрлөлд 1,5 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ, Ерөө сумын Харгана гэх газарт хууль бусаар эрүүл газар ухсан нөхөрлөлийн Hyundai маркийн экскаватор 1, CAT-330D маркийн экскаватор, эвдэрсэн газарт нуусан утгуурт ачигч, түлшний машин, өөрөө буулгагчийг лацдаж, 11,7 гр алтыг хураан авч, тухайн иргэнд эрүүгийн хэрэг үүсгэж шалгаж байна. Мөн Ерөө сумын Бугант тосгоны Агуйт гэх газарт хууль бусаар эрүүл газар ухсан нөхөрлөлийн урал 31 маркийн машин 2, Hyundai маркийн экскаватор 2-ыг албадан буулгаж, эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна. Мөн Баянгол сумын Нарангийн голоос “Бороогоулд” орох замд гарал үүслийн бичиггүй хууль бус мод тээвэрлэсэн 3 тээврийн хэрэгслийг саатууллаа.

Найм.Сум орон нутгийн талаар

Алтанбулаг сум:

“Газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломж” сэдэвт малчдын зөвлөгөөнийг зохион байгуулж, нийт 55 малчин, газар тариалангийн 1 компани оролцож, сумын түүхт 90 жилийн ойн хүрээнд хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцож, мал эмнэлгийн салбарын зорилт, малчдын үүрэг оролцооо, Мерси кор ОУБ-аас хэрэгжүүлж буй “Даван туулах дасан зохицох чадвартай орон нутгийн хөтөлбөр, төсөл”-ийн танилцуулгыг хийж, нийгмийн даатгалын болон хөдөлмөр халамжийн үйлчилгээний мэргэжилтэн нар малчдад үйлчилгээ үзүүлж, мэдээлэл өгсөн.

Сумын хэмжээнд 5-р сарын мэдээгээр нийт 9997 мал төллөснөөс 149 төл хорогдож, 9848 төл бойжиж байна.

Үндэсний бичиг соёлын өдөрт зориулсан “Тунгаамал” тэмцээн, Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Айл бүхэн жаргалтай байг” хүндэтгэлийн арга хэмжээ, уламжлалт “Ахмадын дуун цэнгүүн” арга хэмжээ, “Яргуй” хүүхдийн урлагийн тоглолт болон Бэлчир бүсийн “Бид 20 дугаар зууны залуус” урлагийн наадмыг зохион байгуулсан.

Сумын эрүүл мэндийн төвтэй хамтран хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулж, нийт 102 хүүхдийг үзэж, эцэг эхчүүдэд зөвлөгөө өгсөн. Мөн хүүхдийн байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, нутаг орныхоо онцлогтой танилцуулах үүднээс явган аялалыг зохион байгуулж ахлах болон бэлтгэл бүлгийн хүүхдүүд хамрагдлаа. Мөн Улаанбурхан өвчинд цэг тавья уриан дор 10-18 насны 490 хүүхдийг вакцинжуулалтанд хамрууллаа.

Сумын Ерөнхий боловсролын сургууль “Өсвөр үеийн эрүүл мэнд ба бэлгийн эрүүл мэнд” сэдвээр нийт ахлах ангийн 47 сурагчид мэдээлэл өгч, бяцхан сурагчдын эрдмийн баярын арга хэмжээ болон сумын Засаг даргын ивээл дор “Медалиа зүүцгээе” хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгууллаа.

Баруунбүрэн сум:

Сумын хэмжээнд 12600 га талбайд тариалалт хийхээс 5-р сарын 24-ний байдлаар 7500 га талбайд улаан буудай, 300 га талбайд тосны ургамал, 60 га талбайд төмс, 43,5 га талбайд хүнсний ногоо тариалсан дүнтэй байна.

Том малын хорогдлын мэдээгээр 462 мал, үүнээс адуу 54, үхэр 68, хонь 160, ямаа 180 толгой хорогдсон байна. Мал төллөлтийн хувьд 39157 толгой мал хээлтэгч төллөснөөс 72567 толгой хээлтэгч төллөхөөс 39157 толгой мал төллөж 2748 толгой төл хорогдсон дүнтэй байна.

Сүргийн чанарыг сайжруулах зорилгоор “Газар агро” ХХК-аас нэг бүрийн 3,0 сая төгрөгийн өртөг бүхий 2 бяруун бух авч сэлбэсэн.

Тус сумын уугуул Жалтаан гуайн үр хүүхдүүд нь Бургалтайн аманд өөрийн хөрөнгөөр шинэс 600 ширхэг, нарс 1100 ширхэгээр ойжуулалтын ажлыг хийсэн. Мөн байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар санхүүжигдэх Цөлжсөн элсний нүүлтэд өртсөн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах, хуш, сибир жодооны тарьц суулгацаар ойжуулалт хийх ажлын хүрээнд “Ойн Ирээдүй” мод үржүүлгийн газраас шинэс 9500 ш, жодоо 30 ш тарьц авч ойжуулалтын ажлыг эхлүүлэхээр бэлтгэлийг хангаад байна.

Сумын 2018 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан аудитын дүгнэлтээр зөрчилгүй санал дүгнэлт авсан. Жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүллээ.

Сэлэнгэ аймаг Баруунбүрэн сумын Тусгай зориулалтын байгууллага болон орон нутгийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, санхүүгийн мэдээ мэдээллийг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу үнэн зөв бодитойгоор гаргаж дээд шатны удирдлагад санхүүгийн мэдээллээр хангах, төсвийг үр ашигтай зарцуулах, өр авлага үүсгэхгүй байх, санхүүгийн холбогдолтой тайлан тооцоог ил тод мэдээллэж байх зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд сумын эрүүл мэндийн төвөөс амбулаторийн 225, урьдчилан сэргийлэх 115 үзлэгийг хийж, ээлжит дархлаажуулалтанд 29 хүүхдийг хамруулж, бусад тусламж үйлчилгээг шуурхай үзүүлж ажиллалаа.

Сумын сургууль, цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж, суралцагчдын болон эцэг эхчүүдийн дунд сургалт хүмүүжлийн олон арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Үүнд:

-“Дэлхийн гэр бүлийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх сургалт, сурталчилгааны ажил, “Танай хүүхэд сургуульд ороход бэлэн үү” амьдрах ухааны чиглэлээр 260 зөвлөмж, боршуурыг эцэг эхчүүдэд тараалаа. Мөн ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдын дунд “ АСТ”-ийн тэмцээн, “Санхүүгийн боловсрол ” сэдэвт аяны хүрээнд Өрхийн төсөв, Мөнгөө хэрхэн удирдах вэ?, Хуримтлал ба хадгаламж сэдвээр сургалт явууллаа.

-Үндэсний бичиг үсгийн баярыг угтаж МХБУЗ-ын багш нартай хамтран тусгаар тогтнолын баталгаа болсон монгол бичгийг сургах, сурч эзэмших явдлыг дэмжиж, түгээн дэлгэрүүлэх, монгол бичгийг сэргээн хэрэглэх, эх хэлээ дээдлэх, төрийн бодлогын хэрэгжилтийг идэвхжүүлэх зорилгоор дараах сургалт, уралдаан тэмцээнүүдийг амжилттай зохион явууллаа.

Хүүхдийн сургалт хүмүүжлийн ажилд оролцох арга зам” судалгааг цэцэрлэгийн 94 эцэг эхээс 9 асуулгын дагуу авч дүгнэлт хийж ажиллалаа. Хүүхдийн математик сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор “Дүрсээ нэрлэе” арга хэмжээг зохион байгуулж, бэлтгэл бүлгийн нийт 50 гаруй хүүхдүүдийн дунд “АХА” тэмцээнийг зохион явууллаа.

Тайлант сард “Спорт, Урлаг-2019” аяны хүрээнд сагсан болон гар бөмбөг, дардасын тэмцээнийг зохион байгуулснаас гадна Ардчилсан нам байгуулагдсаны ой, Татвар төлөгчдийн өдөрт зориулсан спортын тэмцээнүүдийг зохион байгууллаа.

Мандал сум:

Сумын “Удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг улирал бүр хийж байгаа бөгөөд 2-р улирлын зөвлөгөөнийг 4-р сарын 30-ны өдөр зохион байгуулж, нийт 80 гаруй албан тушаалтнууд оролцлоо. Зөвлөгөөнөөр хүүхэд хамгаалал, охидын жирэмслэлт, зорилтот өрхийн хөгжил хамгааллын өнөөгийн байдал, насанд хүрээгүй хүүхдээс үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдлын танилцуулга “Хүүхэд хамгааллын бодлого жишиг баримт бичиг”, “Эцэг эхийн зөвлөл” байгуулах зөвлөмж, гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх тухай захирамжийг танилцуулж, “Нийтийн хог цэвэрлэгээ”, Байгаль орчны тасаг, Нийгмийн даатгалын тасгийн мэдээллийг сонсож, цаг үеийн асуудлуудаар мэдээлэл хүргэлээ.

Хууль зүйн туслалцаа үзүүлэх “ХУУЛЬЧИЙН ПРО-БОНО ӨДӨР” арга хэмжээг зохион байгуулж, Мандал сумын Засаг даргын Тамгын газар, Мандал сум дахь сум дундын Шүүх, Мандал сум дахь Сум дундын Прокурорын газар, Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс, Мандал сумын өмгөөлөгчдийн зөвлөл, нотариатын газрууд оролцож, 150 гаруй иргэдэд үйлчилгээ үзүүллээ.

Сумын хэмжээнд 6500 га талбайд үр тариа, 420 га талбайд төмс, 320 га талбайд хүнсний ногоо тариалж тариалалтын явц 85 хувьтай байна.

Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн 20 хувь бүрдсэн тул сумын ИТХ-аар нэг төсөлд олгож зээлийн дээд хэмжээ болон төсөл сонгон шалгаруулах товыг тогтоон, төслийн материалыг хүлээн авах хугацааг иргэдэд нээлттэй мэдээллэснээр 50 төслийг хүлээн авч хөнгөлөлттэй зээл хүсч буй зээлдэгч, хамтран зээлдэгчдийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн сангаас лавлуулахад бэлэн болоод байна.

Сумын хэмжээнд бүх нийтийн цэвэрлэгээг 5-р сарын 4-ний өдөр зохион байгуулж, 5 тн, 20 тн-ын өөрөө буулгагч, портер, бонго зэрэг 44 ачааны автомашин, түрэгч, авто ачигч зэрэг 12 техник, нийт 56 тээврийн хэрэгсэл, 58 аж ахуйн нэгж байгууллагын 1128 албан хаагчид, 44 оюутан, 210 сурагч хамрагдаж, 394 машин буюу 2299 тонн хогийг хогийн нэгдсэн цэгт зөөж, нийтийн эзэмшлийн 80 га талбайг цэвэрлэлээ.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөс гарсан байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмжийн хүрээнд сумын 60 байгууллагын

зөвлөлийн дарга нарыг чадваржуулах сургалтыг зохион байгуулж эцэг эхийн зөвлөл хэрхэн ажиллах талаар чиг үүргийг танилцуулж гэр бүл судлаач Н. Амартүвшинг урьж мэдээлэл хийлээ.

Үндэсний бичиг үсгийн өдрийг сумын хэмжээнд ЕБС-иудын сурагчдын дунд зохион байгуулснаас гадна байгууллага аж ахуй нэгжүүдэд үндэсний бичиг үсгийн соёлыг таниуллаа.

Дархан-Уул аймгийн Мөнгөтийн таг ТББ-тай хамтран "Ахмад настны өдрийн үйлчилгээ"-г СББХК-ийн соёлын төвд зохион байгууллаа. Тус үйлчилгээнд 250 ахмад настан хамрагдаж дараах 10 төрлийн үйлчилгээг авсан. Мөн "Бум Хараа" ХХК-тай хамтран сэргээн засах үйлчилгээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй нийт 100 иргэнийг хамруулж бумба тавих, хаш чулуун ор, цахилгаан зүү, хөл гарын массаж, шарлага, зэрэг эмийн бус эмчилгээ үзүүллээ.

Олон Улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан "Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах нь" үндэсний хөтөлбөр, Хүнсний цаасан эрхийн бичгээр хүнсний бүтээгдэхүүн олгож буй дэлгүүртэй хамтран ажиллах гэрээний дагуу "Сайн үйлсийн аян"-ыг Ч.Баярхүү захиралтай "Шүүтийн өвөр" ХХК-ий Төөнт дэлгүүртэй хамтран 3-р багийн иргэн М.Бүжинлхамд өргөө цагаан гэрийг хүнсний бүтээгдэхүүний хамт гардууллаа. Мөн зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд нийт 22 төсөл ирснээс хүнсний ногоо тариалах, оёдлын чиглэлээр 16 өрхийн 8 төсөл дэмжигдэж бүлэг тус бүр 1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг буцалтгүй тусламж хэлбэрээр авах нөхцөл бүрдлээ.

Баянгол сум

Сумын Засаг даргын 2019 оны А/104 тоот Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай захирамж гарч ажлын хэсэг томилон архивын улсын үзлэгт төр, төсвийн байгууллагуудыг бэлтгүүлэх талаар чиглэл өгч хяналт тавин ажиллаж байна.

Тус сумын хэмжээнд 2019 оны 05 дугаар сарын 05-ны өдөр "Идэр Хурд"-2019 Хаврын бага 3 насны морьдын уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд хязаалан насны морьдын уралдаанд 32, шүдлэн насны морьдын уралдаанд 32, даага насны морьдын уралдаанд 38 морь уралдлаа.

Мөн "Баян Хайрхан" уулыг тахиx овоо тахилгын ажлыг 5-р сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Тахилгын баярт зориулан их нас, дааганы уралдааныг зохион байгуулсан. Дээрх уралдаануудын үеэр гарсан ямар нэгэн зөрчилгүй, хүүхэд бэртэж гэмтсэн тохиолдол гараагүй байна.

2019 оны хаврын тариалалт сумын хэмжээнд 5-р сарын 08-ны өдрөөс эхлэж, 2019 оны 05 сарын 24-ний байдлаар үр тариа тариалалт 55 хувьтай, улаанбуудай 4550 га-д, төмс 32,5 га-д, хүнсний ногоо 12,7 га-д тариалаад байна.

Мал эмнэлгийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын нэгдсэн удирдамжийн дагуу 87 өрхийн 101 толгой адуу, 23 үхэр, 24 хонь, 61 ямаа, 3320 кг адууны мах, 2130 кг үхрийн мах, 2710 кг хоньны мах, 840 кг ямааны мах, 100 кг гахайны мах, 60 хонины арьс, 20 ямааны арьс, 1400 литр сүүнд гарал үүслийн гэрчилгээ олгож, шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг 2019 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс эхэлсэн ба хийж, 90 гаруй хувьтай байна.

Сумын Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 06-ний өдрийн А/99 тоот Бүх нийтээр мод тарих ажлын зохион байгуулах тухай захирамжийн дагуу төр төсвийн болон хувийн хэвшлийн 14 аж ахуйн нэгж байгууллагуудад нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг хувиарлан өгч модны усалагаа хийх, хашаа хайсыг засах, хог хаягдлыг цэвэрлэх ажилд 170 гаруй ажилтан албан хаагчид ажилласан. Мод тарих үндэсний өдрөөр Хараа багийн ирэгн П.Дагвадорж өөрийн хашаандаа 600 хайлаас, Нарт буян хангай нөхөрлөл 1600 хайлаас, Төмөр замын 10-р хэсэг 40 агч, 20 улиас, Ногоон буян ТББ 40 улиас, 60 агч мод тус тус тарьж ногоон байгууламжаа нэмэгдүүллээ. Ой, хээрийн түймэр гарч болзошгүй эрсдэл өндөртэй Баян багийн

Нарангийн ам гэх газарт Онцгой байдлын газрын харъяа Гал түймэр унтраах Аврах 40 дүгээр ангитай хамтран байнгын хяналтын цэгийг ажиллуулж байна.

Ой, хээрийн түймэр гарсан тохиолдолд ашиглахаар нөөцөлсөн багаж хэрэгслийн бэлэн байдлыг шалгаж Портер авто машин -2 ширхэг, Ланд крузер-100 авто машин -1 ширхэг, үлээгч аппарат 3 ширхэг, цохиур 190 ширхэг, 31 ширхэг троссон цохиурууд бэлэн байдалд байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах эрхийн бичийг 1 аж ахуйн нэгж, 4 иргэнд голын хайрга 94 тн, элс 38 тн, дайрга 33 тн бэлтгэхээр олгож 287000 төгрөгийг төрийн санд тушаасан. Ашигт малтмал, газрын тосны газраас Дархан-Уул аймагт зохион байгуулсан “Бичил уурхайн нэгдсэн мэдээллийг сангийн программ хангамж”, “Бичил уурхайн мэдээлэл цуглуулагч аппликейшн” сэдэвт сургалтанд хамрагдсан.

Монгол Улсын Сагсан бөмбөгийн 3х330 төслийн хүрээнд сумын аварга шалгаруулах тэмцээнийг анх удаа зохион байгуулж ажиллалаа. Тэмцээнд нийт 12 р багийн 50 гаруй тамирчин оролцсон.

Сумын ЗДТГ-аас санаачлан Баян багийн иргэн Г.Эрдэнэхуягийн эмчилгээний зардалд зориулсан “Сүүн сэтгэл” хандивын тоглолтыг дугуйлангийн суралцагчид, ахмад, залуу ардын авьяастнуудтайгаа хамтран зохион байгуулж 55 авьяастан тоглолтонд оролцож нийт 235 иргэн үзэж сонирхлоо.

Амбулаториор нийт 611 иргэнийг үзлэгт хамруулан, дээд шатлалын эмнэлэгт 26 иргэнийг онош тодруулахаар илгээсэн. Хүлээн авах хэсгээр 341 иргэнд өдрийн эмчилгээг эмчийн заалтаар хийж үйлчилсэн. Ээлжит нөхөн дархлаажуулалтыг сумын хэмжээнд 5-р сарын 15-аас 25-ны өдрүүдэд “Улаанбурханд цэг тавья” уриан дор зохион байгуулж, 10-18 насны 638 хүүхдийг улаанбурхан өвчний эсрэг дархлаажуулалтанд хамруулсан байна.

Клиник болон биохимийн шинжилгээнд 216 хүнийг хамруулсан.

Цэцэрлэгийн түүхт 50 жилийн ойг угтсан төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байна. Л.Тогтох багштай Бага Б бүлгийн санаачилсан “Гал тогооны тоног төхөөрөмж” төслийг Бороо гоулд ХХК ивээн тэтгэж амжилттай хэрэгжүүллээ.

Мөн “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аян -2019” нэрийн дор “Цүнхтэй аян”-ыг өрнүүлж сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудад ХАБЭА-н тухай хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, дүрэм, журам баримт бичгийн бүрдлийг бий болгон хэвшүүлэн ажиллаж байна. Уг арга хэмжээний хүрээнд нийт 5 байгууллагын 85 ажилчдад сургалт зохион байгуулан ажилласан байна. Тус аяны хаалтын ажиллагааны арга хэмжээг 2019.05.07-ны өдрийн 11 цагт Майнд тэч ХХК-ний үйлдвэрийн барилгыг түшиглэн ГТУА 40- анги, ЭМТ-ийн эмч ажилтан, албан хаагч нарт үзүүлэх сургалтыг зохион байгуулж, нийт 10 аж ахуй нэгж байгууллагын дарга эрхлэгч, ХАБЭА хариуцсан ажилтаны хамт оролцож амжилттай зохион байгууллаа. Мөн хаалтын ажиллагаанд оролцсон нийт ажилтан албан хаагч нарт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Үйлдвэрлэлийн осол хурц, хордлогыг судлан бүртгэх сэдвээр сургалт зохион байгуулж ХАБЭА-н тухай хуулийг сурталчлан ажиллаа.

Ажил хайгч иргэд болон бусад иргэдээ ажлын байрны мэдээллээр хангахын тулд сул чөлөөтэй шинэ ажлын байрны зарыг ажил хайгч иргэдэд утсаар, цахим хаягаар болон биечлэн уулзаж санал болгон мэдээ мэдээллээр ханган, зөвлөгөө өгч ажилласан.

Тухайн сард ажилгүйчүүдийн бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргасан 20 иргэнд сул чөлөөтэй байгаа ажлын байрыг санал болгон, зөвлөгөө, мэдээллээр ханган идэвхитэй ажил хайгчаар Lmis программд бүртгэн авсан.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2, ХБИ-ний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 1, ахмадын санхүүгийн дэмжлэгт 1 иргэн, АБДХ-ийн бүлгийн зохион байгуулалттайгаар төмс, хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 2 бүлгийн 4 иргэнийг тус тус хамруулан ажилласан. Мөн малжуулах хөтөлбөрт хамрагдаар сонгогдсон өрхүүдэд мал худалдах өрхүүдийг бүртгэж холбон зуучлан ажиллаж банья.

2019 оны 4-р сард ажил идэвхитэй ажилгүй 8 иргэнийг байнгын шинэ ажлын байранд зуучлан холбон ажилласан байна.

2017 онд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс батлагдсан төсөл хөтөлбөрүүдэд хамрагдаж зээл авсан иргэдэд үлдэгдэл төлөлтөө гэрээний хугаа дуусах өдөрөөс өмнө төлж барагдуулыг мэдэгдэж Сэлэнгэ аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдэгдэлийг хүн нэг бүрт өөрийн биеэр гардуулан өгч гарын үсэг зуруулах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Орхон сум

Орхон сумын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөл нь 2018 оны ажлаараа Сэлэнгэ аймгийн ШИЛДЭГ Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөл болсон амжилтыг үзүүлж цаашид ажил үйлчилгээгээ улам сайжруулах зорилгыг тавин ажиллаж байна. Үүний хүрээнд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөл”-ийн 2019 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 21 ажил арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн ЗДТГ-ын даргаар батлуулан ажиллаж байна. Сарын аяны хүрээнд төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн ХАБЭА ажилчдад үүрэг чиглэл биелэлтийг хангаж байгаа эсэхийг шалган зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Суманд газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Орхондалай”, “Пубосс”, “Цацрах буудай”, “Мөнх-Орхон”, “Арсайн хүрхрээ”, “Монголбуудай” аж ахуйн нэгжид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм журмыг сурталчлан, аюулгүй ажиллагаа зааварчилгааны дэвтэр аялуулан өглөө бүр ажилдаа гарахдаа гарын үсэг зуруулж байхаар үүрэг чиглэл өглөө.

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд 5 дугаар сарын байдлаар нийт 745 иргэний 112,798,890 төгрөгийг тус тус олгож ажилласан.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 тоот зарлиг, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2019 оны А/156 тоот “Бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулах тухай” захирамж, сумын ИТХ-ын 2017 оны 20 тоот тогтоол “Ногоон төгөл хөтөлбөр”-ийн хүрээнд ЗДТГазар 200ш, ЕБСургууль 120 ш, ЭМТөв 60 ш, Цэцэрлэг 25 ш, Соёлын төв 40 ш, 25 айл өрхөд 50 ш нийт 520 ширхэг нарс модны суулгацыг 1,5 га талбайд тарьж суулгалаа. Тус ажилд төрийн байгууллагын 65 албан хаагч, 35 иргэн оролцлоо.

Сумын хэмжээнд хуваарийн дагуу 2 удаа бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулан албан байгууллагын ойр орчим, нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдал, Дархан-Эрдэнэтийн замаас сум хүртэлх 5 км зам дагуух хог хаягдал зэргийг цэвэрлэсэн. Тус ажилд төр төсвийн 56 албан хаагч ЕБС-ийн 10-12 ангийн 65 сурагч оролцсон. Сумын төв хогийн цэгийн 3 га талбайг хашаажуулах ажил хийгдсэн. Мөн төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг түрж булах ажлыг зохион байгуулан ажилласан. Сумын төвд байрлах хуучин байшингийн суурь, барилгын үлдэгдэл балгасын барилгын гаралтай 70 тн хог хаягдлыг цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Сумын Засаг даргын 2019 оны А/55 тоот “Тариалангийн талбай, өвөлжөөний газрыг малын хөлөөс чөлөөлөх тухай” захирамжийг хэрэгжүүлээгүй 2 малчинд тус бүр 100000 төгрөгийн торгуулийн арга хэмжээг Зөрчлийн тухай хуулийн дагуу авсан.

Оны эхний нийт хээлтэгчийн 77,9 хувь 37195 толгой эх мал мал төллөж гарсан төлийн 38,5 хувь буюу 36660 толгой төл бүрэн бойжиж байна. Хорогдсон төл 535 толгой буюу нийт 1,4 хувийг эзэлж байна.

Сумын төр төсвийн байгууллагууд сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаа хэвийн явагдаж сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчид аймгийн “Багш сурагч солилцоо” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан солилцоогоор ажиллаж, сурагчдын дунд “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” арга хэмжээ, “Улаан бурхан улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтын 10 хоног, Эрдмийн баяр, “Мянган цэцгийн баяр”, Миний ертөнцөд тавтай морилно уу?” Сумын ИТХ-ын нэрэмжит сургуулийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн болон бусад арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Сант сүм:

Сумын хэмжээнд 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 34173 эх мал төллөж, мал төллөлт 82,4 хувьтай байна. Үүнээс гүү 363, үнээ 1310, эм хонь 18600, ямаа 13900 төллөж, төл бойжилт 99,8 хувьтай байна. Том малын зүй бус хорогдол адуу 14, үхэр 42, хонь 69, ямаа 7, нийт 132 байна.

Сумын Засаг даргын захирамжаар зарласан “Ариутгал халдваргүйжүүлэлтийн сарын аян”-ы хүрээнд сумын нутаг дэвсгэрийн 190м² талбайгаас 63 сэг зэм цуглуулж зориулалтын дагуу булж устгав. 1-р багийн 44 өрхийн 63 өвөлжөө, хаваржааны 21194м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж 40 өрхийн 60 нохойд хорхойгүйтгэх туулга хийлээ. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шөвөг ярын вакцин 1, 2-р багийн 94 өрхийн 19300 толгой хурга, ишиг хамрагдаж вакцинжуулалтын ажлыг 100% технологит хугацаанд хийгээд байна.

Сумын “Малчдын зөвлөгөөн” 4-р сарын 26-ны өдөр зохион байгуулагдаж мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломж, Малын генетик нөөцийн тухай хуулийн ач холбогдол, Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр, Нийгмийн даатгалын хуульд орсон өөрчлөлтүүд, Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд учруулсан хохирлыг тооцох аргачлал, Эрүүл мал, эрүүл хүнс, эрүүл хүн сэдвээр илтгэл мэдээлэл хүргэсэн байна. Малчдад зориулсан “Нэг цэгийн үйлчилгээ” нээлттэй хаалганы өдөрлөг явагдаж нийгмийн даатгал, хөдөлмөр халамж үйлчилгээ, улсын бүртгэл, байгаль орчин, татвар, газрын алба, мал эмнэлгийн чиглэлээр давхардсан тоогоор 241 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлэн 68 ширхэг гарын авлага материал тараасан.

Хаврын тариалалтын ажил эхлэж 1843 га талбайд улаанбуудай, төмс 195 га, хүнсний ногоо 59,3 га талбайд тус тус тариалж тариалалтын явц үр тариа 51%, төмс 75%, хүнсний ногоо 42,3%-тай явагдаж байна.

Жимс жимсгэнэ хөтөлбөрийн хүрээнд иргэдийн захиалгын дагуу үхрийн нүд, чацарганы 150 ширхэг суулгацыг Дархан-Уул аймгийн УГТЭШХ-ээс авчирч, 4 иргэнд нийлүүлэн жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Монгол Улсад Атар газар эзэмшиж, газар тариалангийн салбар бие даан шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжсөний 60 жилийн ойн хүрээнд "Атрын 60 жилийн туг", "Хүндэт дэвтэр"-ийг суманд хүлээн авч, газар тариалангийн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан байгууллага, аж ахуйн нэгж, үе үеийн тариаланчдын дурсамж алдарыг мөнхжүүлэх ажлыг зохион байгуулж, хуваарьт хугацаанд Орхон суманд хүлээлгэн өглөө.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 63 дугаар зарлиг бүх нийтээр мод тарих үндэсний өдрийн хүрээнд 23 өрх, 5 аж ахуйн нэгж байгууллага, 11 төрлийн 547 ширхэг жимсний болон бусад төрлийн мод тарьж сумын төвийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүллээ. Ойн санг гэрээгээр эзэмшигч Хан Хушаат нөхөрлөл нэг га ойн сан бүхий талбайд 1400 ширхэг шинэс мод тарьсан байна.

2019 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын ажил Сайхан суманд зохион байгуулагдаж сумаас цэргийн насны 57 иргэн хамрагдаж 4 иргэн цэргийн албанд тэнцсэн байна.

Сум хөгжүүлэх сангийн улсын үзлэг явуулах удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2019 оны А/173 тоот захирамжаар ажлын хэсэг суманд ажиллан 13 чиглэлээр хяналт шалгалтыг гүйцэтгэж сумын дүнгээр 73 хувьтай дүгнэгдсэн байна.

Аймгийн ХХҮГ, Дархан уул аймийн ЖДҮ-ийг дэмжих төвтэй хамтран аж ахуй эрхлэлтийн сургалтын хүрээнд "Бизнесээ хэл, Бизнесээ хөгжүүл" бизнесийн ур чадвар олгох сургалтыг зохион байгуулж 20 иргэн хамрагдлаа.

Сумын ГХУСАЗСЗ, Хүүхэд хамгаалын хамтарсан баг, ЕБС-тай хамтран 2019.05.02-ны өдөр “Хүүхэд бүрийг хамгаалъя” уриан дор “Хүчирхийлэл дарамтаас

хамгаалья” хэлэлцүүлгийг зохион байгуулж ЕБС-ын 6-11 дүгээр ангийн 50 сурагч анги хамт олноо төлөөлөн оролцлоо.Хэлэлцүүлэгт оролцогч сурагчид хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхдийг нийгмийн бүхий л орчинд бүх төрлийн хүчирхийллээс хамгаалах, хүчирхийллийг таслан зогсоох талаар санал бодлоо солилцож, үе тэнгийн найзууддаа, аав ээжүүддээ, сурган хүмүүжүүлэгч багш нартаа, орон нутгийн удирдлагууддаа дуу хоолойгоо хүргэлээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас “Гэгээн үйлс” ТББ-тай хамтран зохион байгуулсан гэр бүлийн аз жаргал, үнэ цэнэ хүндэтгэлийн “Шилдэг гэр бүл-2019” арга хэмжээнд Сант сумаас 2 гэр бүлийн 4 хос оролцож, Баянжаргалын Цэвээнжавын гэр бүл аймгийн “МАНЛАЙЛАГЧ ГЭР БҮЛ”-ээр шалгарсан.

Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан сумын ИТХ, ЕБС, Соёлын төв хамтран “Эх хэл бидний бахархал” 10 хоногийн аяныг зохион байгууллаа. Аяны хүрээнд ЕБС-ийн 6-11-р ангийн сурагчдын дунд үндэсний бичгээрээ зөв цэвэр бичих, уран тод унших, “Уран бийр” бичлэгийн уралдаан, төрийн албан хаагчид иргэдийн дунд “Зөв цэвэр бичигтэн”, “Үндэсний бичгээрээ хэн сайн унших вэ” зэрэг уралдаануудыг явуулж 51 албан хаагч иргэд, 108 сурагчид хамрагдлаа. Уралдаанд ирсэн материалуудаар бүтээлийн үзэсгэлэн гаргалаа.

Сүхбаатар сум

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал хуралдаж хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн тайлан, хүн амын дундах сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын өвчлөл, хүн амын дундах тархалтын талаар авах арга хэмжээний тайлан, төрийн дээд одон медалиар шагнуулахаар ирсэн иргэдийн материалыг хэлэлцлээ.

Сумын 8 багийн иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулж, 2020 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлыг хэлэлцэн баталж эрэмбийг тогтоолоо.

Төрийн үйлчилгээг нэг дор үзүүлэх зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг алслагдсан 1, 5 дугаар багуудад зохион байгууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар хаврын мод тарилт ажлын хүрээнд сумын хэмжээнд 109 өрх айл 897 ширхэг мод, бут, сөөг тарьж, 56 аж ахуйн нэгж байгууллагууд өөрсдийн эзэмшлийн талбайд 1252 ширхэг мод, бут, сөөг, 67 ширхэг цэцгийн мандал, 2000 ширхэг цэцэг тарьялаа. Сумын ЗДТГ-ын хамт олон ТЗ-н клубээс урагшаа зам дагуу 84 ширхэг нарс, банкуудын холбоо 50 ширхэг нарсан төгөл байгуулж ажиллалаа. Мөн сургууль цэцэрлэгийн орчинд мод тарих хөдөлгөөн өрнүүлэх шинээр мод тарих хийх үүргийг сургуулиудад өгч нийт 4,6 га газар ногоон байгууламж хийж 314 ширхэг мод тарьялаа.

УИХ-ын гишүүн Н.Оюундарийн дэмжлэгээр нийт сургууль төгсөгч болон ахлах ангийн 600 гаруй хүүхэд эцэг эхчүүдийн дунд “МЭРГЭЖИЛ СОНГОЛТ -2019” сургалтыг зохион байгуулж, “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг сумын хэмжээнд тэмдэглэ өнгөрүүлэх ажлыг зохион байгуулж, Улсын тэргүүний 4-р сургуулийн монгол хэл, уран зохиолын багш, шавийн хамт бийрэн монгол бичгийн үзэсгэлэнг гаргаж, олон нийтэд танилцууллаа. Мөн уг ажлын хүрээнд байгууллагын ажиллагсадын дунд монгол бичгийн сургалт, аж ахуйн нэгж байгууллагуудын хаяг, лого зэргийг монгол крилл бичгээр бичих, зөв цэвэр сайхан бичигтэнг шалгаруулах ажлыг сургууль цэцэрлэг бүрт зохион байгуулж, хаяг, нэрийн хуудас, өргөмжлөл, талархал зэргийг монгол бичгээр хослон бичих хөдөлгөөнийг өрнүүллээ.

Олон Улсын “Гэр бүлийн өдөр”-ийг тэмдэглэх удирдамжийг гарган сумын үлгэр дууриал болсон шилдэг тэргүүний өрх гэр бүлүүдийг сурталчлах, өргөмжлөх туршлагыг нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг баг бүрт хийж 8 баг тус бүрээс шилдэг өрхийг сонгон баг дээрээ өдөрлөг зохион шалгарууллаа.

Сүхбаатар сумын Засаг даргын санаачлгаар Ерөнхий боловсролын Спорт сургуультай хамтран “Сурагчдын лиг-2019” сагсан бөмбөгийн аварга шалгаруулах

анхдугаар тэмцээнийг 3 дугаар сараас эхлэн зохион байгуулж байгаа ба сарын 07-ны өдөр албан ёсоор нээлтээ хийлээ.

5-р

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/207 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2019 оны А/174 тоот захирамж, сумын Засаг даргын 2019 оны А/129 тоот захирамжийн дагуу сумын хэмжээнд нэмэлт дархлаажуулалтын 10 хоногийг 2019 оны 5 дугаар сарын 15-наас 25-ны өдрүүдэд “Улаанбурханд цэг тавья” уриан дор сумын 10-18 насны бүх хүүхдийг хамруулж ажиллахаар төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ба 05 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар Номт хан өрхийн эрүүл мэндийн төв 98,9%, Эмнэх баг өрхийн эрүүл мэндийн төв 67,9 хувьтай байна.

Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтын дагуу Сэлэнгэ аймгийн ХХҮГ, Дархан-уул аймгийн “Мөнгөтийн таг” ХХК-тай хамтран 2019 оны 05 дугаар сарын 19-ны өдөр “Ахмад настны өдрийн үйлчилгээ”-г Сүхбаатар суманд зохион байгуулж, 8 багийн нийт 150 ахмад настныг хамрууллаа.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтын дагуу Сэлэнгэ аймгийн ХХҮГ, “Энэрэлт-Үйлс”, ЭБУС хувийн эмнэлэгүүдтэй хамтран 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн “Сэргээн засах үйлчилгээ”-г Сүхбаатар суманд зохион байгуулж байгаа ба ахмад настан 80, хөгжлийн бэрхшээлтэй 80 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 40 хүүхэд, нийт 200 иргэнийг хамруулахаар ажиллаж байна.

Сумын Засаг даргын А/100 тоот захирамжийн дагуу бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулж, өөрийн эзэмшлийн 50м газрын эргэн тойрон хогийг цэвэрлүүлж, суманд үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллага 45, аж ахуйн нэгж 78, 1327-н айл өрхийн 2100 иргэн, албан хаагч нар хог цэвэрлэгээнд идэвхи санаачлагатай оролцож нийт 90 тонн хогийг төв хогийн цэгт буулгалаа.

Хушаат сум:

Сумын Тариаланчдын зөвлөгөөн зохион байгуулагдаж зөвлөгөөний үеэр "Монгол ногоо" төслийн хүрээнд "Эко Хушаат" борлуулалтын хоршоо хүнсний ногооны үрийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж "Хүнсний ногоо хатаах, боловсруулах цех"-ийн нээлтийн ажиллагаа боллоо. "Эко Хушаат хоршоо"-ны үйл ажиллагааг дэмжин зорь, хашаа барих зориулалтаар 80м/куб модны зөвшөөрөл олгон үйл ажиллагааг нь дэмжлээ. Зөвлөгөөнд сумын Засаг дарга Б.Атартулга "Хушаат сум дахь Атрын 3-р аяны ойн ажил арга хэмжээний хэрэгжилт, цаашид тавих зорилт" илтгэл, ХААТ-ийн дарга Т.Баасандорж "2019 оны хаврын тариалалтын ажлын технологийн бодлого", цаг уурч Х.Өлзийсайхан "2019 оны дулааны улирлын цаг уурын урьдчилсан төлөв", "Монгол ногоо" хөтөлбөрийн зохицуулагч Т.Төрмандах "Монгол ногоо хөтөлбөрийн Хушаат сум дахь хэрэгжилт, цаашдын зорилт" илтгэлүүд тавигдлаа.

Хаврын тариалалтын ажил эхэлж 5-р сарын 20-ны байдлаар улаанбуудай 4373 га, төмс 172 га, хүнсний ногоо 95,2 га, үүнээс лууван 45 га, сонгино 50 га, сармис 0,2 га тариалаад байна. Тариалалтын штаб, ургацын хохирол тооцох ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Таримал ургамлыг малаас хамгаалах тухай сумын Засаг даргын албан даалгавар гарч мөрдөн ажиллаж байна.

Мал эмнэлэг, эрүүл ахуй, ариутгал халдваргүйжүүлэлтийн сарын аяныг зохион байгуулж зам даваа, булаг шанд, голын ойр орчмын 10 малын хүүр сэг зэмийг цэвэрлэж, 1600 мкв задгай талбай, 16500 мкв өвөлжөө хөшөө, 7 худаг уст цэг ариутгаж халдваргүйжүүлсэн.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ойн сан бүхий Артойлбын чиглэлд Онцгой байдлын газрын 2 албан хаагч, сумын 2 байгаль хамгаалагч, 4 морьт эргүүл байнгын хяналтын постонд гарч ажиллаж байна. Ой хээрийн болон объектын түймэр гараагүй байна. Бүх нийтийн мод тарих өдрөөр нийт 10 өрх, 3 төсвийн байгууллага, 4 төрийн бус байгууллага нийт 766 ш мод, бут тарьсан. “Тогосын нарс” ХХК Артойлбод 3 га-д ойжуулалт хийу, “Соёолж” ХХК цэцэрлэгт хүрээлэнд 6 төрлийн 440 мод, бут тарьж арчлан ургуулж байна. Хуурайшилтын улиралтай холбогдуулан аливаа хууль бус ан агнуур, ойд зорчих, халиар түүхэд гарах зөрчлөөс урьдчилан

сэргийлэх зорилгоор 2 удаа хяналт шалгалтыг хийж 8 тээврийн хэрэгсэл, 36 иргэн хамрагдлаа.

Орхон бүсийн ЗДТГ-ын төрийн албан хаагчдын дунд уламжлал болон зохион байгуулагддаг урлаг спортын нөхөрсөг тэмцээнд урлагийн 5 төрөл, спортын 6 төрлөөр бэлтгэн амжилттай оролцлоо.

Арабын Нэгдсэн Эмират Улсын Абу Даби хотноо зохион байгуулагдсан Жюу жицү бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож Дэлхийн аварга, дэлхийн аваргын медаль хүртсэн тус сумын тамирчдаа хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ. Тус сумын харьяат Гансүхийн Батцэцэг 52 кг жинд алтан медаль авч Дэлхийн аварга, Саранбаярын Шинэхүү 42 кг жинд мөнгөн медаль, Ганбатын Мөнхтуяа 40 кг жинд хүрэл медаль авч Хушаатчуудаа баярлуулсан билээ. Г.Батцэцэг, С.Шинэхүү, Г.Мөнхтуяа, Б.Батзориг нарыг сумын "Хүндэт дэвтэр"-т бичин алдаршуулж тамирчдын хүүхдүүд болон аав ээж, ах дүү нараас дасгалжуулагч багш З.Сэлэнгэбаяр, О.Батбаяр нарт талархал илэрхийлж, бөхийн дэвжээ авах асуудлыг шийдлээ.

Улсын тэргүүний шилдэгийн шилдэг Ахмадын байгууллага, аймгийн Хүндэт тэмдэгт аймгийн Ахмадын хороо "Удирдах ажилтны VI зөвлөгөөн"-өө Хушаат суманд зохион байгууллаа. Энэ үеэр зарим ахмадуудыг алдаршуулах ажлыг зохион байгуулж, сумын соёлын төвийн дэргэдэх бүжгийн дугуйлангийн Болор-2 хамтлагийн хүүхдүүд хүндэтгэл үзүүлж, мэндчилгээ дэвшүүллээ.

Улаан бурхан өвчний дархлаажуулалтын аяны хүрээнд сумын 10-18 насны хүүхдийн 97.5% буюу 163 хүүхэд хамрагдахаас 162 хүүхдийг нэмэлт дархлаажуулалтанд хамрууллаа. Сумын эрүүл мэндийн төвийн хүсэлт, Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатын дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотын Өргөө ротари клуб, Герман улсын Ландау хотын иргэн анагаах ухааны доктор Альфердтай хамтран 10 ширхэг функциональор, шүүгээний хамт гардуулан өглөө.

Сумын "Яргуй" цэцэрлэг 05 сарын 01нээс 05 сарын 27- ны байдлаар хамран сургалт нийт 2200 хүүхэд хүлээн авахаас 1606 хүүхэд авч ирц 73%-тай байна.

Тайлант сард сумын хэмжээнд төрөлт-1, эцэг тогтоолт 2, гэрлэлт 2, нас барсан 1, цахим үнэмлэх дахин авах 2, шилжин ирсний 10, биеийн давхцахгүй өгөгдлийн 4, үл хөдлөх хөрөнгийн эрхийн 1, газар өмчлөх эрхийн 6, иргэний үнэмлэх олголтын 6, нийт 38 бүртгэл хийж, 7 гэрчилгээ бичиж олгов.

Нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр тэтгэмжийг олгож үйлчиллээ.

Хүдэр сум:

Тус суманд авто тээврийн үзлэг 5-р сарын 11, 12-ны өдөр зохион байгуулагдаж нийтдээ 343 тээврийн хэрэгсэл хамрагдаж, орон нутгийн төсөвт 11262,1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.

ЕБС-ийн сурагчдад "Мэргэжил бүхэн сайхан" сэдэвт сургалт, "Эх дэлхийгээ хайрлан хамгаалъя" сургалт, "АХА тэмцээн, "Зөнгийн одод миний эх орон" сэдэвт найрал дууны тэмцээнийг зохион байгуулснаас гадна эцэг эхийн хурлыг зохион байгуулж, нийт 307 эцэг эх хамрагдсан.

СӨБ-аас төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг зохион байгуулж, сумын эрүүл мэндийн төвтэй хамтран хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа. Үзлэгт 225 хүүхэд хамрагдсан. Мөн "Бяцхан даамчин", "Цэцэрлэг минь баяртай" урлагийн тоглолтыг тус тус зохион байгуулсан.

Сумын эрүүл мэндийн төвөөс тайлант сард амбулаторын үзлэг 326, урьдчилан сэргийлэх 53 үзлэг хийгдэж, жирэмсний хяналтанд 27 байна. Нэмэлт дархлаажуулалтанд хамрагдвал зохих 64 хүүхдийг бүрэн хамруулж, "Улаанбурханы эсрэг вакцинд 10-18 насны 345 хүүхдийг хамруулж, хачигт халдвараас сэргийлэх вакцины тунг 20, 2-р тунг 68 иргэнд тус тус хийсэн.

Нийгмийн даатгалын болон Халамжийн тэтгэвэр тэтгэмжийн хугацаанд нь олгож, нийтийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг барагдуулах хуваарийг гарган хэрэгжүүлж байна.

Энэ сард төрсний бүртгэлд 6, шилжих суурьших хөдөлгөөний бүртгэл 6 хийгдэж, цахим үнэмлэхээ гээгдүүлсэн 1, шинээр 9 иргэний цахим үнэмлэхийг олгож, 3 иргэнд архивын лавлагаа гаргаж үйлчилсэн.

Сумын хэмжээнд 8 аж ахуйн нэгж тариалалтанд гарч, одоогийн байдлаар 2600 га-д улаан буудай, 80 га-д арвай, 200 га-д овъёос, 5 га-д төмс тариалсан мэдээтэй байна.

Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг “Нэг иргэн 1 мод, нэг байгууллага 5 мод” уриан доор зохион байгуулж, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төв хамтран 6 төрлийн 249 ширхэг мод, бутыг гадаа талбайдаа тарьж, 10 өрх, ойн санг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгж, Хилийн салбарууд хамтран 1 км газарт хашаа барьж, хаягжуулан 5 төрлийн 379 ширхэг мод бутыг тарьж сум орон нутгийнхаа тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүллээ.

Зүүнбүрэн сум:

Атар газар эзэмшсэний түүхт 60 жилийн ойн нээлтийн арга хэмжээг сумандаа зохион байгуулж, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нар болон үеийн тариаланчид хамрагдлаа.

2019 оны хаврын тариалалтын хугацааг тогтоох тухай болон тариалалтын байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар 7214 га-д улаан буудай, 140 га талбайд төмс, хүнсний ногоо тариалаад байгаа ба, улаан буудай тариалалт 80 гаруй хувьтай байна.

Суманд мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа “Энхбүрэн сүрэг”, “Оюут сүрэг” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн мал эмнэлгийн шуурхай бэлэн байдлыг шалгаж, ажлын байр, тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгаалалыг дүгнэж, нэгдсэн үнэлгээг холбогдох байгууллагад хүргүүллээ. Мөн Дархан-уул аймагт зохион байгуулагдах “Монгол, Солонгосын хамтарсан хүнс, хөдөө аж ахуй, барилга, аялал жуулчлалын экспо” арга хэмжээнд оролцох газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг 3 аж ахуйн нэгж, сүү, сүүн бүтээгдэхүүн эрхлэгч 1, аялал жуулчлалын 1, худалдаа үйлчилгээний чиглэлийн 1 бизнес эрхлэгчдийн судалгааг гарган хүргүүлсэн.

Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, мал эмнэлгийн ариун цэвэр халдваргүйжүүлэлтийн аяныг зохион байгуулснаар Бэлчир багийн Охь-хөндийн халдварт өвчний голомтын бүсийн 12 га бэлчээр, 8 өрхийн өвөлжөө хаваржааг ариутгалд хамрууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 тоот зарлигын дагуу Сэлэнгэ сав голын сав газар Ерөнхий боловсролын сургууль аж ахуй нэгжүүдтэй хамтран 604 ширхэг мод, жимс жимсгэний 300 ширхэг бут суулгалаа.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны зорилтын хүрээнд хүүхдийн хүмүүжил, төлөвшилд үндэсний өв уламжлал, урлаг соёлоор дамжуулан эерэгээр нөлөөлөх бодлого хэрэгжүүлэх, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилготой “Монгол хүүхдүүд” аймгийн хүүхдийн урлагийн их наадам 13 хүүхэд амжилттай оролцоноос 11а ангийн сурагч Г.Одмаа “Дэд байр”-нд шалгарсан амжилт гарган улсад оролцох эрх авсан амжилттай ирсэн.Хөгжмийн хичээл- Бидний хөгжилд” сэдэвт дугуйлангийн сурагчдын урлагийн тайлан тоглолтыг зохион байгуулж давхардсан тоогоор 126 сурагч, 12 багшийг хамрууллаа.

“Хүмүүнлэгийн сургууль” болох зорилтын хүрээнд 465 хүүхэд 20 багш оролцон тангараг өргөлөө. “Үндэсний бичиг үсэг” өдрийг тохиолдуулан 8-11-р ангийн сурагчдын дунд түргэн бичлэг, уран бичлэг, таталган бичлэгийн уралдаан зарласан сурагчдын бүтээлийг 3 чиглэлээр дүгнэн 18 сурагчийг шагнаж урамшууллаа.

“Монгол уламжлалын цаг” хөтөлбөрийн хүрээнд ХОУЗ-ийн “Могол соёл” бүлгийн сурагчидтай хамтран “Монгол наадгай сурах” арга хэмжээ зохин байгуулж 10 тоглоомыг шинээр хийж, тоглох аргачлалыг 135 сурагчдад зааж өглөө.

Багш сурагч солилцоо хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ЕБС-тай хамтран ажиллалаа. Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын

сургуулийн 8, 10 дугаар ангийн 2 сурагч Баруунбүрэн сумын ЕБС-ийн 8, 10-р ангийн 2 сурагчтай солигдон 7 хоног суралцлаа. “Халуун дулаан сэтгэл” хүмүүнлэгийн арга хэмжээг 4 дүгээр сарын 25-наас 5 дугаар сарын 10 хүртэл 14 хоногийн хугацаанд зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд багш сурагчид мод тарих, ахмад багшдаа ногоо тарьж өгөх, будаа цуглуулж ахмадуудад тараах, ангийн эмзэг бүлгийг хүүхдэд туслах зэрэг ажлуудыг зохион байгуулж 400 гаруй сурагч, 16 багш, 10 эцэг эх, 4 ахмад багшийг хамрууллаа.

“Цахим орчин –Эрсдлээс өөрийгөө хамгаалах нь” сургалтыг дунд, ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж 196 сурагчдыг хамрууллаа.

2018-2019 оны хичээлийн жил дуусч байгаатай холбогдуулан 2а, 3а, 4б, 5а, 6а ангийн сурах бичгүүдийг хураан авч гэмтэлтэй ном хэвлэлийг сэлбэн засах ажил явагдаж байна.

“Улаан бурхан өвчинд цэг тавья” аяны хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 4-11 дүгээр ангийн 299 сурагчыг вакцинжуулалтанд хамрууллаа.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаж буй 5 хүртэлх насны 64 хүүхдэд А витамин уулгалаа.

14 дүгээр цэцэрлэгийн түүхт 60 жилийн ойн хүрээнд бүтээн байгуулалтын ажлыг эхлүүллээ.

Иргэний гэр бүлийн тухай хуулийн хүрээнд шинэ төрсөн 4, иргэний үнэмлэх олголтын 18, иргэний үнэмлэх дахин авах 3, биеийн давхацахгүй өгөгдлийн бүртгэл 11, шилжин ирсэн 2 нийт 38 бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүллээ.

Жавхлант сум:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2019 оны А/128 тоот захирамжийн дагуу 2019 оны нэгдүгээр ээлжийн хугацаат цэргийн албаны татлагад 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн 67 залуучуудад зарлан мэдэгдэх хуудсыг тарааж, 39 залуу эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагдлаа. Мөн сумын тээврийн хэрэгслийн улсын үзлэгийг 5-р сарын 6, 7-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 223 тээврийн хэрэгслийг хамруулсан.

Багуудын Иргэдийн нийтийн Хурлыг зохион байгуулж, 2020 онд сумын ОНХС-аас хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн саналыг авч, эрэмбэллээ. Энэ үеэр сумын Засаг дарга 2018-2019 онд улс аймаг, сумын хөрөнгө оруулалтаар хийж хэрэгжүүлсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын үр дүн, явцын талаар болон тус сумаас алга болсон хүүхдийн талаар Цагдаагийн байгууллагаас хийж буй эрэл хайгуулын талаар санал бодол солилцон, мэдээлэл өглөө. Арга хэмжээнд нийт 246 иргэн хамрагдсан.

Төр төсвийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, “Атар газар эзэмшсэний 60 жил”-ийн ойг тохиолдуулан газар тариалангийн аж ахуйн нэгжүүдийг сурталчлах, хамтын ажиллагааг сайжруулах, иргэдийг мэдээллээр хангах эерэг хандлагыг бий болгох зорилготой “БАЙГУУЛЛАГА СУРТАЛЧИЛАХ” 14 хоногийн аяныг зохион байгуулан ажиллаж байна.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Ерөө бүсийн төрийн захиргааны албан хаагчдын урлаг, спортын тэмцээнд сумын ЗДТГ-ын хамт олон амжилттай оролцож, "Тэргүүн байрт" шалгарч өргөмжлөл шилжин явах цомын эзэн боллоо.

Тус сумын Бумбат 1-р багийн иргэн Д.Бибишийн хүүхэд алга болсонтой холбогдуулан аймгийн цагдаагийн газрын 40 албан хаагч, Улсын онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэх газраас 9 хүн нийт 49 цагдаагийн албан хаагч эрэн хайх ажлыг 36 дах хоногтоо явуулж байна. Хүүхэд алга болсон тухай мэдээлийг бүх чиглэлээр эрэн сурвалчилж байгаа мэдээллүүдийг тавьж, зарим худал мэдээлэлд тухай бүр залруулга хийж ажиллаж байна. Хайгуулын ажилд одоогийн байдлаар хоол хүнс, шатахууны зардалд 10,0 орчим сая төгрөгийг зарцуулаад байна.

Энэ сард сумын эрүүл мэндийн төвд нийт 346 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 202, амбулаторын үзлэг 144 хийж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэн, хөнгөлөлттэй жороор 10 иргэнд үйлчилж зөвлөгөө өгч ажилласан. Аймгийн хэмжээнд анх удаа хөдөөгийн алслагдсан малчид, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэн ажиллуулах зорилгоор орон

нутгийн хөрөнгө оруулалтаар Моностой 2-р багийн төвд багийн эмчийн үйл ажиллагааны байрыг ашиглалтанд оруулсан.

Улсын хэмжээнд хийгдэж байгаа улаанбурхан, улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалт 5 дугаар сарын 15-ны өдрөөс 25-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 10-18 насны нийт 190 хүүхдийг хамруулсан.

Аймгийн засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Ахмад багш нарын мэдлэг, чадвар, арга туршлагаас хуваалцах, зөвлөн туслах чиглэлээр ажиллах, зөвлөгөө зөвлөмж өгөх, залуу багш нарт түгээн дэлгэрүүлж, ажлын үр дүнг тооцно” заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд БСУГ-ын ахмад мэргэжилтэн Түүх нийгмийн ухааны багш Х.Сувдаа, Монгол хэл уран зохиолын багш Л.Дорждамба, математикийн багш н.Лхагвасүрэн, хими биологийн багш н.Жавзанпагма, бага ангийн багш н.Нарангэрэл гэсэн бүрэлдэхүүнтэй 5 ахмад багш хүрэлцэн ирж ЕБС-ийн үйл ажиллагаатай танилцан, багш нарын хичээлд сууж арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллалаа.

Дэлхийн номын баярыг тохиолдуулан ЕБС-ийн номын санч, соёлын төвийн номын санч хамтран 1-5-р ангийн сурагчдын дунд зохион байгуулсан “**Бээлий хүүхэлдэй**” 6-11-р ангийн сурагчдын дунд “**Эсгий ном**” урлахуй тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

Монгол үндэсний эх хэлний боловсролын чанар, хэрэглээ, эх хэлний дархалааг сайжруулах, баримтат өв соёл, дурсгалыг сурталчлах түгээх зорилгоор зохион байгуулсан үндэсний бичиг үсгийн баяраар “Шилдэг үндэсний өв тээгч” зөв цэвэр бичигтэн тэргүүн байранд ЕБС-ийн сургалтын менежер С.Цогзолмаа, дэд байранд Г.Нямсүрэн “Шилдэг үндэсний соёлын өвөө эрхэмлэгч” байгууллагаар ЕБС тэргүүн байр, “Шилдэг үндэсний бичиг үсэг сонордуулагч” түргэн тод уншигчаар 11а ангийн сурагч Б.Оюунбилэг, дэд байранд 11а ангийн сурагч Б.Мөнхжавхлан, нар тус тус шалгарч шагналын эзэд боллоо.

Сумын хэмжээнд хаврын тариалалт 52% явагдаж байна.Үүнд: Улаанбуудай 16 аж ахуй нэгж нийт 4880 га, 2 аж ахуй нэгж, 38 иргэн төмс, хүнсний ногоо 69 га талбайд тариалалт хийгдсэн байна.

Атарын 60 жилийн ойн хүрээнд “Газар хүн хоёрын түүх” баримтат кино болон гавъяат механикжуулагч Д.Түвдэн, ахмад агрономич Д.Агваанбалган, дунд үеийн тариаланч Бадрадтрейд ХХК захирал С.Эрдэнэбат, залуу тариаланч Хурниад ХХК механикжуулагч Д.Баярцогт нарын сэтгэгдэл сонсож, орчин үеийн газар тариалангийн чиг хандлага усалгаатай тариалангийн талаар “Өгөөмөр хантайж” ХХК-ий захирал Б.Цогтсаран нар мэдээлэл хийжлээ. 2018 оны аж ахуй нэгжтэй хамтран ажиллах гэрээгээ сайн биелүүлсэн “Хурниад” ХХК, “Жавхлант буудай” ХХК, хамгийн сайн татвар төлөгч аж ахуй нэгжээр “Өгөөмөр хантайж” ХХК, “Анар энх” ХХК-ууд шалгарч, нийт 92 ахмад, дунд, залуу тариаланчид хамрагдсан байна.

Иргэдийн амьдрах ая тухтай орчинг бүрдүүлэх, сумын өнгө үзэмжийг сайжруулах, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй халдварт өвчнөөс сэргийлэх, зорилгоор сумын Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй 10 иргэнд цалин хөлсийг нь олгож, төвлөрсөн хогийн цэгийн гялгар уут сав баглаа боодлыг цэвэрлүүлж, хогийн цэгийн жижиг хог хаягдлыг хийсэхээс хамгаалж салхины чиглэлийн дагуу 400 м торон хашаа татах ажлыг хийж гүйцэтгүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 63 дугаар зарлиг, Байгаль хамгаалах сарын аяны хүрээнд төр, төсвийн 5 байгууллага, ХААН банк, ахмадын хороо, иргэд хашаандаа 7 нэр төрлийн 279 ширхэг гоёлын мод, 4 нэр төрлийн 121 ширхэг жимсний мод, нийт 400 ширхэг мод бут, цэцэг зүлэг тарьж ногоон орчинг бий болгоод байна.

Цагааннуур сум:

Тайлант сард сумын Засаг даргын Тамгын газрын иргэний танхимаар дамжуулан “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-т бэлтгэхэд анхаарах асуудлын талаар сумын төр, төсвийн байгууллагуудын холбогдох мэргэжилтнүүдэд зориулсан сургалт, “Хангай” үүлдрийн

хонь үржүүлж эхэлсний 60 жилийн ойг угтан хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга уулзалтыг малчидтай зохион байгуулж, “Гамшгийн эрсдлээр бууруулах бэлэн байдлын сургалт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд “Аж ахуй эрхлэлт”-ийн сургалтыг тус тус зохион байгуулсан.

Аймгийн Стандартчлал хэмжилзүйн хэлтсийн мэргэжилтнүүд тус суманд ажиллаж сумын худалдаа, үйлчилгээний газруудад холбогдох стандартын дагуу ээлжит тохирлын үнэлгээг хийлээ.

“Хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо” сумын зөвлөгөөнийг 5-р сарын 3-нд зохион байгуулж, 748 эсэг эх хамрагдсан бөгөөд хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цахим гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар мэдээлэл өгсөн.

Оргих, Хуурч, Тийрэг багуудын иргэдийн нийтийн хурлыг энэ сарын 20, 21, 24-ний өдрүүдэд зохион байгуулж, багийн Засаг даргын ажлын тайлан, 2020 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын саналыг авч, цаг үеийн ажил арга хэмжээний талаар мэдээлэл өгч, иргэдийн санал хүсэлтийг сонслоо.

Тайлант сард Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд тус сумын “Сэлэнгэ тари” ХХК-ий тариалалтын явцтай танилцсан.

Малчдын өвөлжөө, хаваржааны тооллогыг багийн Засаг дарга, газрын даамлууд хийж, 74 өвөлжөөны координатын байршлыг тогтоон мэдээллийн санд оруулснаар сумын хэмжээнд нийт 179 өвөлжөөний мэдээллийг шивсэн дүнтэй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу “Бүх нийтээр мод тарих өдөр”-өөр Сум дундын ойн анги, иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд хамтран 1410 мод, 1366 бут сөөг тарьж, 5 м2 талбайд зүлэгжүүлэлт, 6 м2 талбайд цэгийн мандал байгууллаа.

Сумын төр, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа хэвийн явагдаж, нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь олгосон.

Сумын хэмжээнд авто тээврийн үзлэг оношлогоо хийгдэж, үзлэгт нийт 500 гаруй тээврийн хэрэгсэл хамрагдлаа.

ХЯНАСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ТӨРИЙН
ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.БОЛОРЗУЛ

БОЛОВСРУУЛСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ш.ЭНХМАА